

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-21

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 22-49

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 22-49

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
06 дугаар сарын 07-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 33 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Г.Ганболд, Л.Оюун-Эрдэнэ, Х.Нямбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг.

Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Хуулийн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Мэдээллийн технологийн төвийн референт А.Банзрагч, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Б.Болд, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга А.Энхмаа, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Наранцэцэг, мөн газрын Мэдээллийн технологийн газрын мэргэжилтэн С.Дэлгэрмөрөн, судлаач Э.Гэрэлт-Од нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын даргын зөвлөх О.Номинчимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгийн гаргасан тусгайлсан саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүнээс 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 2 гишүүнээс 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг хамтатган хэлэлцэх горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6

Бүгд: 13
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хасах:

“1/4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг:

4.3.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 126 гишүүнийг дараах байдлаар сонгоно:

4.3.1.Улсын Их Хурлын 78 гишүүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос олныг төлөөлөх /мажоритар/ аргаар;

Тайлбар: “олныг төлөөлөх /мажоритар/ арга” гэж тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү бөгөөд хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.

4.3.2.Улсын Их Хурлын 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорциональ/ аргаар.

Тайлбар: “хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорциональ/ арга” гэж сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн авсан саналынх нь тоо, хувьд үндэслэн энэ хуульд заасны дагуу суудал хуваарилж, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт, мөн зүйлийн 16 дахь заалтыг нэгтгэн 1 дүгээр зүйлийн 19 дэх заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дугаар зүйлийн 5 дахь заалтыг хасах:

“19/20 дугаар зүйлийн 20.22 дахь хэсэг:

20.22.Гадаад улсад байгаа иргэн гадаадад санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө сонгуульд оролцохоо мэдэгдэж, бүртгүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.4.4 дэх заалт, 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.6-7.10 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалтыг хасах:

“7/9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг:

9.3.Гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдөр /цаашид “гадаадад санал авах өдөр” гэх/-ийг сонгуулийн төв байгууллага /цаашид “Сонгуулийн ерөнхий хороо” гэх/-ын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоох бөгөөд гадаадад санал авах өдөр нь дөрөв хүртэл өдөр байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 11.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10, 11 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10/11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг:

11.4.Улсын Их Хурлын гишүүнийг энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар сонгох сонгуульд Монгол Улсын нутаг дэвсгэр сонгуулийн нэг тойрог байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 12, 13 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

12.2.Энэ хуулийн 4.6-д заасны дагуу ээлжит бус сонгууль явуулах тохиолдолд Улсын Их Хурал ээлжит бус сонгуулийн санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө энэ хуульд нийцүүлэн сонгуулийн тойргийг байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 19¹ дүгээр зүйлийн 19¹.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“19¹.3.Төв комиссын дарга дотоод ажлын асуудлаар захирамж гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтын 19¹ дүгээр зүйлийн гарчгийн “бүрэн эрх,” гэснийг хасаж, 19¹.7 дахь хэсгийн “эрхийг” гэснийг “чиг үүргийг” гэж, 19¹.7.10 дахь заалтын “эрх” гэснийг “чиг үүрэг” гэж, 19¹.7.2 дахь заалтын “сахин биелүүлэх явдлыг хангах” гэснийг “хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.16 дахь хэсгийн “танилцах” гэсний дараа “, ашиглах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 19 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.18 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2 дугаар зүйлийн 6 дахь заалтыг хасах:

“19/20 дугаар зүйлийн 20.21 дэх хэсэг:

20.21.Энэ хуульд заасан журмын дагуу Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, төрийн бус байгууллагын төлөөлөл сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаатай танилцаж нягтлах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 20 дахь заалт буюу 23.8 дахь хэсгийн “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас” гэснийг “холбогдох байгууллагаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дэх заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

24/29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэг:

“29.10.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөлөл, оролцоог хангаж, тэгш боломж олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 27 дахь заалт буюу 33.1.10 дахь заалтын “дэвшигчийг” гэсний дараа 29.7-д заасныг зөрчсөн бол тухайн нэр дэвшигчийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 28 дахь заалт буюу 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсгийн “хэмжээнээс” гэснийг “хэмжээний 50 хувиас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 29 дэх заалтын 38.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.13.Төрийн аудитын дээд байгууллага нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн энэ хуулийн 38.5-д заасан мөрийн хөтөлбөр, 38.7-д заасан хандивын тайланд тус бүр нэг дүгнэлт гаргана. Хандивын тайлан нь ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааг, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацааг хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 31 дэх заалтын 41.16 болон 41.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.16.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь тухайн нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг эрхлэн явуулна.

41.17.Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь гурван хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 33 дахь заалт буюу 47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32/47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсэг:

47.12.Жагсаалтаар нэр дэвшигчийн цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага энэ хуульд заасны дагуу бүртгүүлсэн цахим хуудсаар эрхлэн явуулна. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахад энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 34 дэх заалт буюу 48 дугаар зүйлийн 48.1.8-48.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34/48 дугаар зүйлийн 48.1.8 дахь заалт:

48.1.8. тухай жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх, амлалт өгөх, зарлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 35 дахь заалт буюу 48 дугаар зүйлийн 48.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34/48 дугаар зүйлийн 48.10 дахь хэсэг:

48.10. Радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Саангэрэлийн тавьсан асуултад Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 37 дахь заалт буюу 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37/53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэг:

53.4. Энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 6

Бүгд: 11

45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 6

Бүгд: 11

45.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 37 дахь заалт буюу 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37/53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэг:

53.4.Энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 38, 39 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37/59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг:

59.4.Саналын хуудас нь дараах хэсэгтэй байна.

59.4.1.энэ хуулийн 4.3.1-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшигчид санал тэмдэглэх;

59.4.2.энэ хуулийн 4.3.2-т заасан нам, эвсэлд санал тэмдэглэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 41 дэх заалт буюу 63¹ дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 42 дахь заалт буюу 64¹ дүгээр зүйлийн 64¹.1 дэх хэсгийн “Сонгуулийн ерөнхий хорооноос” гэснийг “энэ хуульд заасны дагуу” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 43 дахь заалт буюу 65 дугаар зүйлийн 65.16, 65.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“65.16.Сонгогчийн нэрийн жагсаалтын нэгдсэн санд бүртгэлийн хуудас авсан сонгогчийг ялгах тэмдэглэгээ хийнэ.

65.17.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 65.6-д заасан сонгогчийн гарын хурууны хээгээр сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай тулган таниулах үйл ажиллагааг хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Ц.Туваан нарын тавьсан асуултад Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Наранцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 44 дэх заалтын 67¹ дугаар зүйлийн 67¹.4, 67¹.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“67¹.4.Энэ зүйлд өөрөөр заагаагүй бол гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагаанд энэ хуулийн 65, 66 дугаар зүйлд заасан журмыг баримтална.”

“67¹.6.Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн энэ хуулийн 59.4.2-т заасан хэсэгт саналаа өгнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 45 дахь заалт буюу 67 дугаар зүйлийн 67.17 дахь хэсгийн “төв комисст” гэсний дараа “гадаадад санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 48 дахь заалт буюу 71 дүгээр зүйлийн 71.11 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 49 дэх заалт буюу 72¹ дугаар зүйлийн 72¹.4 дэх хэсгийн “дипломат төлөөлөгчийн газарт” гэснийг “салбар комисст” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 50 дахь заалтын 74.1 дэх хэсэг, 74.1.3, 74.1.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 51 дэх заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.2.2 дахь заалтын “3” гэснийг “4” гэж өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлийн 52 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 53 дахь заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсгийн 74.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“74.3.2.Энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвслийн авсан саналын хувь болон нийт нам, эвсэлд өгсөн хүчинтэй саналын хувь хоорондын зөрүүг энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвсэлд тэнцүү хэмжээгээр хуваан нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 53 дахь заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.3.3 дахь заалтын “38-д” гэснийг “48-д” гэж, 74.3.4 дэх заалтын “38-д” гэснийг “48-д” гэж тус тус өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлийн 54 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 53 дахь заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 74.3.5 дахь заалт нэмж, 74.3.4 дэх заалтын тайлбарыг хасах.

“74.3.5.энэ хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3.4-т заасны дагуу нэг суудалд ногдох саналын хувьд хуваахдаа бутархай нарийвчлалтай гаргаж, эхний ээлжид бүхэл хэсэгт нь тэнцэх суудлыг хуваарилах, хэрэв хуваарилагдаагүй суудал үлдвэл хамгийн их үлдэгдэлтэйгээс нь эхлэн нэг нэгээр суудлыг нам, эвсэлд нэмж хуваарилах зарчмаар бүх суудлыг хуваарилж дуусгана.

Тайлбар: Хуваарилагдаагүй суудал гэж энэ хуулийн 74.3.4-т заасны дагуу нам, эвслийн авсан саналын бүхэл хэсэгт нь ногдох суудал хуваарилахад суудал хуваарилагдаагүй үлдсэн, мөн нам, эвслийн авсан саналд ногдох суудлын тоо нь тухайн нам, эвслийн жагсаалтаар нэр дэвшигчийн тооноос их тооцогдсоны улмаас суудал хуваарилагдаагүй үлдэхийг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг:

4.2.Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 14 дүгээр зүйлийн 14.12 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 8, 9 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8/30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг:

“30.1.Нам, эвсэл нь 78 хүртэл хүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрогт, 48 хүртэл хүнийг нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 7
Бүгд: 11

36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11

45.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10

70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 8, 9 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8/30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг:

“30.1.Нам, эвсэл нь 78 хүртэл хүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрогт, 48 хүртэл хүнийг нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1 дүгээр зүйлд нэмж, дугаарлалтуудыг өөрчлөх:

“30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг:

30.3.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг:

42.1.Тойрог тус бүрд нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан дараах шаардлагыг хангасан нэгдсэн самбартай байна. Сум, дүүргийн засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан журмын дагуу нэгдсэн самбарыг бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулна.

42.1.1.энэ хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн зурагт хуудсыг байрлуулах дарааллыг тогтооно;

42.1.2.сонгуулийн сурталчилгааны нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй ашиглуулна;

42.1.3.нэгдсэн самбарт байрлуулах нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны дөрөвний нэг хэмжээтэй байна;

42.1.4.сонгогчийн тоонд үндэслэн суманд хоёр хүртэл, хороонд гурав хүртэл нэгдсэн самбар байрлуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг:

42.1.Тойрог тус бүрд нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан дараах шаардлагыг хангасан нэгдсэн самбартай байна. Сум, дүүргийн засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан журмын дагуу нэгдсэн самбарыг бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулна.

42.1.1.энэ хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн зурагт хуудсыг байрлуулах дарааллыг тогтооно;

42.1.2.сонгуулийн сурталчилгааны нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй ашиглуулна;

42.1.3.нэгдсэн самбарт байрлуулах нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны дөрөвний нэг хэмжээтэй байна;

42.1.4.сонгогчийн тоонд үндэслэн суманд хоёр хүртэл, хороонд гурав хүртэл нэгдсэн самбар байрлуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу 48.9 дэх хэсгийн “орохыг” гэснийг “орох, нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигч ухуулах байр ажиллуулахыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“50.2.Сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох аргачлал нь сонгуулийн зардлыг бууруулахад чиглэх бөгөөд сонгуулийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, энэ хуульд заасан бусад шаардлагад үндэслэнэ. Аргачлалыг төрийн аудитын дээд байгууллагын саналаар Сонгуулийн ерөнхий хороо батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 14 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14/65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг:

65.6.Санал авах байранд ажиллаж байгаа итгэмжлэгдсэн ажилтан сонгогчийн гарын хурууны хээг сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбартай тулгаж, энэ хуулийн 66.5-д заасан бэхэн тэмдэглэгээ хийгдсэн эсэхийг нягтлан, зөрчилгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“66.2.Сонгогч энэ хуулийн 59.4.2-т заасан хэсэгт нэг нам, эвсэлд саналаа өгнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“66.5. Сонгогч саналаа тэмдэглэсэн саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийсний дараа тухайн сонгогч саналаа өгснийг илэрхийлэх бэхэн тэмдэглэгээг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу хийнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

47. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “иргэн” гэсний дараа “гадаад улсад суугаа Монгол Улсын иргэн” гэж,” гэснийг, “20.1 дэх хэсгийн “шийдвэрлэх ажлыг” гэсний дараа “Сонгуулийн ерөнхий хорооны хяналт дор” гэж, “зохион байгуулж,” гэсний дараа “энэ хуульд заасан журмын хүрээнд” гэж, 20.5 дахь хэсгийн “холбогдох мэдээлэлтэй” гэсний дараа “болон байнга оршин суугаа хаягт бүртгэлтэй бусад сонгогчдын мэдээлэлтэй” гэж, 20.13 дахь хэсгийн “цахим хэлбэрээр” гэсний өмнө “санал авах өдрөөс 5 хоногийн өмнө 2 удаа” гэж,” гэснийг, 20.15 дахь хэсгийн “жагсаалтыг” гэсний дараа “хуульд зааснаас бусад тохиолдолд” гэж,” гэснийг, ““жагсаалт дахь” гэсний дараа “энэ хуулийн 20.5 дахь хэсэгт заасан” гэж, “буруу бүртгэгдсэн,” гэсний дараа “байнга оршин суугаа газрын хаягт нь бүртгэлгүй сонгогч нэмэгдсэн зэрэг асуудлаар” гэж,” гэснийг, “, мөн хэсгийн “нэвтрүүлнэ.” гэсний дараа “Сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний хуваарь, цагийг тэнцүү хэмжээнд тогтооно.” гэж,” гэснийг, “67 дугаар зүйлийн 67.14 дэх хэсэгт “67.13” гэсний өмнө “67.1” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

48. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “харилцах” гэсний өмнө “хороотой” гэж, “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “Нэр дэвшигч нь” гэсний өмнө “Сонгуулийн тойрогт” гэж, “54 дүгээр зүйлийн” гэсний өмнө “51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “эвсэл болон” гэсний дараа “сонгуулийн тойрогт” гэж,” гэж, “54 дүгээр зүйлийн 54.2 дахь” гэсний дараа “хэсгийн “эсхүл” гэсний дараа “сонгуулийн тойрогт” гэж,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

49. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “хороо” гэсний дараа” гэснийг “мөн зүйлийн 10.4 дэх хэсгийн “захиргааны байгууллага” гэсний дараа “, сум, дүүрэг” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “болон хэсгийн хороо” гэсний дараа” гэж, “50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийн” гэснийг “50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсгийн” гэж, “тоо нь саналаа өгсөн нийт сонгогчийн” гэснийг “тоо нь тухайн хэсгийн хорооны хүлээн авсан саналын хуудасны” гэж, “, нам, эвсэл тэдгээрээс жагсаалтаар нэр дэвшигчийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам, эвсэл болон жагсаалтаар нэр дэвшигчид нэгээс илүү санал тэмдэглэсэн” гэснийг “, нам, эвслийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам, эвсэлд санал тэмдэглэсэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “11 дүгээр зүйлийн” гэсний өмнө “10.1.14 дэх заалтын “46, 47, 48.9-д” гэснийг “46, 47 дугаар зүйл, 48.9, 48.10-д” гэж,” гэж, “13 дугаар зүйлийн” гэсний дараа “13.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэр, төвийг” гэснийг “нутаг дэвсгэрийг” гэж, мөн зүйлийн” гэж, “21 дүгээр зүйлийн” гэсний өмнө “20.15 дахь хэсгийн “хувилж олшруулах,” гэснийг “энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хэвлэж” гэж,” гэж, “21.1 дэх хэсгийн” гэсний дараа ““нутаг дэвсгэр, төвийг” гэснийг “нутаг дэвсгэрийг” гэж,” гэж, “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө “38 дугаар зүйлийн 38.7, 38.8, 38.12 дахь хэсгийн “26.3.6, 26.4.6” гэснийг “38.13” гэж,” гэж, “46.4 дэх хэсгийн” гэсний өмнө “зүйлийн 46.2 дахь хэсгийн “тогтоосон” гэснийг “баталсан” гэж,” “Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран” гэсний өмнө “журмыг” гэж, “Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн” гэсний өмнө “, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмыг” гэж, “60 дугаар зүйлийн” гэсний өмнө “58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсгийн “26.3.6, 26.4.6, 38.5” гэснийг “38.5, 38.13” гэж,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө” гэснийг “цахим хэлбэрээр нэг удаа” гэж, “нам, эвсэл бүртгүүлснээс хойш ажлын 3 хоногт” гэснийг “болон санал авах өдрөөс 3 хоногийн өмнө тус тус цахим хэлбэрээр” гэж, “32.11 дэх хэсгийн “тав” гэснийг “долоо”” гэснийг “32.11 дэх хэсгийн “хүлээн авснаас хойш тав” гэснийг “хүлээн авах хугацаа дууссанаас хойш долоо”” гэж, “хугацаа” гэснийг “хуваарь, цагийг” гэж, “тэдгээрээс тойрогт болон жагсаалтаар нэр дэвшигч, бие даан” гэснийг “тэдгээрээс тойрогт нэр дэвшигч, бие даан” гэж, тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “20 дугаар зүйлийн 20.11, 23.1, 24.1, 24.2, 24.3 дахь хэсгийн “14-өөс” гэснийг “16-аас” гэж, 20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсгийн “14-өөс доошгүй” гэснийг “5-аас доошгүй” гэж,” гэснийг, “42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн “аймгийн төв болон дүүргийн нэг хэсэгт 5, бусад хэсэгт 3-аас” гэж,” гэснийг, “50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийн “харгалзан Сонгуулийн ерөнхий хороо болон Монгол Улсын Ерөнхий аудитор хамтран батална.” гэснийг “үндэслэл болгоно.” гэж,” гэснийг, 5 дугаар зүйлийн “13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “, төвийг” гэснийг,” гэснийг, “29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийн “ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд” гэснийг,” гэснийг, “54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “нам, эвсэлд, эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш” гэснийг,” гэснийг, 6 дугаар зүйлийн “4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2, 12 дугаар зүйлийн 12.4, 14.12 дахь хэсэг, 20 дугаар

зүйлийн 20.15 дахь хэсэг” гэснийг, “50 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг,” гэснийг, “, 65 дугаар зүйлийн 65.6 дахь заалтыг” гэснийг, “26.3.5,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн, Т.Доржханд, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ж.Сүхбаатар нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “30 дугаар зүйлийн 30.20 дахь хэсгийн” гэсний дараах ““20-иос” гэснийг “30-аас” гэж” гэснийг ““20-иос” гэснийг “40-өөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Д.Сарангэрэл нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

54.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “13 дугаар зүйлийн” гэсний өмнө “10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “улсын төсвөөс санхүүжих” гэснийг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “32.12 дахь хэсгийн “22” гэснийг “18” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 10
Бүгд: 12
16.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

56.Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд “Саналын хуудаст нам, эвслийн нэрийг Улсын Их Хурлын өмнөх сонгуульд авсан суудал, саналын тооны ихээс бага руу жагсааж, дарааллын дагуу бичнэ.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 8
Бүгд: 12
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Найруулгын санал

Н.Энхболд: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 43 дахь заалт буюу 67¹ дугаар зүйлийн дугаарыг 66¹ болгож, 3 дугаар зүйлийн “10.4 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “, улсын хил хамгаалах байгууллага, батлан хамгаалах байгууллага, архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж,” гэснийг “10.4 дэх хэсгийн “дээд байгууллага” гэсний дараа “, батлан хамгаалах болон архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын хил хамгаалах” гэж,” гэж, “дагалдах хэрэглэл” гэснийг “дагалдах хэрэгсэл,” гэж, 5 дугаар зүйлийн “, 20.6.8” гэснийг “, 20.6.7, 20.6.8” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн “холбоотой өөрчлөлтийн” гэсний дараа “талаар” гэж, 7 дугаар зүйлийн “48 дугаар зүйлийн” гэсний өмнө “29 дүгээр зүйлийн 29.7, 29.8 дахь хэсгийн дугаарыг “29.8, 29.9” гэж,” гэж, мөн зүйлийн “48 дугаар зүйлийн” гэсний өмнө “30 дугаар зүйлийн 30.3, 30.4 дэх хэсгийн дугаарыг “30.4, 30.5” гэж,” гэж нэмж, 7 дугаар зүйлийн “12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн дугаарыг 12.4 гэж” гэснийг, “71 дүгээр зүйлийн “71.11, 71.12, 71.13, 71.14, 71.15, 71.16, 71.17, 71.18” дахь хэсгийн дугаарыг ““71.12, 71.13, 71.14, 71.15, 71.16, 71.17, 71.18, 71.19” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийн “хяналтын дэд хорооны” гэсний дараа “, Сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төсөл

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Н.Энхболд: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “чиглэлээр” гэсний дараа “Сонгуулийн автоматжуулсан системийн тухай” гэж нэмж, мөн заалтын “12 дугаар сарын 31-ний” гэснийг “10 дугаар сарын 01-ний” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар санал хурааж дэмжигдсэн зарим зарчмын зөрүүтэй саналын томъёолол Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зохицуулалттай зөрчилдсөн эсэх, хэрхэн нийцүүлэх, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбоотойгоор нэгтгэсэн төслийн дагаж мөрдөх хугацааг нийцүүлэх талаарх эрх зүйн дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 08 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 17 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
15 цаг 33 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүдийн ирц 68,4 хувиар бүрдсэн байна, 13 гишүүн байна. Адъяасүрэн гишүүн, Амарсайхан гишүүн, Батсуурь гишүүн, Доржханд гишүүн, Занданшатар дарга, Оюунчимэг гишүүн, Пүрэвдорж гишүүн, Сарангэрэл гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Энхболд гишүүн, Эрдэнэбат гишүүн, 13 хүний ирцтэй байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн, ирц бүрдсэн тул 2022 оны 6 сарын 7-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслүүд анхны хэлэлцүүлэг хийнэ. 2 хуулийн төсөл өргөн мэдүүлсэн. Их Хурлын гишүүн Энхболд нарын 4 гишүүн 4 сарын сарын 5-ны өдөр, Их хурлын гишүүн Цогтгэрэл, Ганбат нар 4 сарын 5-ны өдөр мөн хуулийн төсөл өргөн мэдүүлсэн. Нэгтгэж хэлэлцэх асуудлаа ярина өнөөдөр.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Их Хурлын Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн санал, дүгнэлтээ танилцуулна. Би урьд өмнө нь Улсын Их Хурлын даргын захирамжаар энэ 2

хуулийг нэгтгэж хэлэлцэх тухай захирамж гарсан. Ахлагчаар нь Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, гишүүдэд Бат-Амгалан, Баттөмөр, Ганибал, Доржханд, Мөнхцэцэг, Одонтуяа, Сарангэрэл, Туваан, Энх-Амгалан, Энхбаяр нар орсон. Сүүлд нь захирамжид нэмэлт заалт оруулаад Пүрэвдорж гишүүнийг бас нэмсэн байгаа. Ийм ажлын хэсэг хуулийн төслүүд дээр ажилласан. Тогтохсүрэн даргыг ажлын хэсгийнхээ тайлбар санал, дүгнэлтийг танилцуулахыг урьж байна. Тогтохсүрэн даргын микрофоныг өгөөрэй.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн.../үг тасрав/

Н.Энхболд: Тэр горимын дагуу санал хураалгах юм байна. Нөгөө нэгтгэж хэлэлцье гэдгээр нь. Явж бай, явж бай. Тогтохсүрэн гишүүний.

Д.Тогтохсүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 4 гишүүн 2023 оны 4 сарын 5-ны өдөр, Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл, Ганбат нарын гишүүд мөн 23 оны 4 сарын 5-ны өдөр тус тус Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг 2023 оны 4 сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг шийдэж Төрийн байгууллагатай байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын даргын 2023 оны 4 сарын 19-ний өдрийн 79 дүгээр захирамжаар 2 төслийг нэгтгэн Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгээ байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар Тогтохсүрэн миний бие, гишүүдээр Бат-Амгалан, Баттөмөр, Ганибал, Доржханд, Мөнхцэцэг,Ц,

Одонтуяа, Пүрэвдорж, Сарангэрэл, Туваан, Б.Энх-Амгалан, Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажилласан. Төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий Ажлын дэд хэсгийг Улсын Их Хурлын Тамгын газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Гадаад харилцааны яам, Үндэсний аудитын газар, СЕХ, улсын ерөнхий УБЕГ, Харилцаа холбооны зохицуулах хороо болон судлаачдын төлөөллийг оролцуулан байгуулж ажиллалаа.

Ажлын хэсэг 2023 оны 6 сарын 6-ны өдөр хуралдсан. Нэгдсэн төсөлтэй холбогдуулан 55 хамт, өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдолтой 4 зарчмын зөрүүтэй саналын саналын томъёолол бэлтгэн та бүхэнд тараасан болно. Энэ 4 биш шүү дээ. Энэ 50 гаруй юм байх ёстой тоо нь. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дараах хүрээнд багтааж бэлтгэсэн болно.

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн Улсын Их Хурлын 126 гишүүнийг гишүүний 78 гишүүнийг сонгуулийн тойргоос олныг төлөөлөх буюу мажоритар аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх буюу пропорциональ аргаар сонгохоор оруулж ирсэн.

2.Гадаад улсад суугаа иргэдээс санал авах өдрийг Улсын Их Хурал тогтоох бөгөөд 4 хүртэл өдөр байх, гадаадад байгаа иргэдийн саналыг авах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Төв комисс болон салбар комиссын чиг үүрэг гадаадад сонгууль авах үйл ажиллагааны зохион байгуулалттай холбогдох зарим асуудлыг тусгах.

3.Сонгогч тойрогт тухайн тойргийн мандаттай тэнцүү тооны нэр дэвшигчид болон нам эвсэл санал өгөх.

4.Төрийн аудитын дээд байгууллага, нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр болон хандивын тайлан гаргах, сонгуулийн зардлын дээд хэмжээг батлах.

5.Сонгуулийн зардлыг бууруулах чиглэлээр тойрог тус бүрд нэр дэвшигчийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбартай байх зохицуулалтыг тусгах.

6.Нам, эвсэл нам нэр дэвшүүлэхдээ намын гишүүн дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хандив, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглох. Ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж нийгмийн төлөөллийн оролцоог бүрэн хангах.

7.Жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг нам эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага эрхлэн явуулах.

8.Сонгогчдын нэрийн жагсаалтад давхардал байгаа эсэхийг нь нягтлан шалгуулах зорилгоор сонгуульд оролцож байгаа нам эвсэлд цахим хэлбэрээр 2 удаа нэрсийн жагсаалтыг өгөх зэрэг асуудлуудыг хамруулан авч үзлээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс боловсруулан оруулж байгаа зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Байнгын хорооны гишүүд та бүхнээс хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Тогтохсүрэн даргад баярлалаа. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа мөн ажлын хэсгийн нэрийг танилцуулъя. СЕХ-ны дарга Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Баяндүүрэн, Улсын Их Хурлын даргын зөвлөх Номинчимэг байна уу? Энд ирчихсэн байна. ГХЯ-ны Консулын газрын захирал Болд, Үндэсний Аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх

аудитор Бундхорол, ХХЗХ-ны Ажлын албаны дарга Лувсан-Очир, СЕХ-ны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, ГХЯ-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Энхмаа, УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранцэцэг, УБЕГ-ын Мэдээллийн технологийн газрын Мэдээллийн сангийн программ хангамжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Дэлгэрмөрөн, СЕХ-ны мэдээллийн технологийн төвийн референт Банзрагч, судлаач, доктор Гэрэлт-Од ийм хүмүүс хуралдаанд оролцож байна.

Хуралдааны, Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асууж болно. Асуулт асуух хугацаа 4 минут, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минут тайлбар хангалтгүй гэж үзвэл тухайн гишүүн 1 минутаас илүүгүй хугацаагаар дахиж асууж, тайлбар авч болно. Тогтохсүрэн гишүүн горимын санал. Тогтохсүрэн гишүүний.

Д.Тогтохсүрэн: Ажлын хэсгийн ахлагчийн хувьд нэг горимын санал гаргах гэж байгаа юм. Ажлын хэсэг 2 төслийг нэгтгэн 1 төсөл болгосон. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нараас өргөн мэдүүлсэн Сонгуулийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг суурилсан, тэгээд Цогтгэрэл нарын гишүүдээс өргөн мэдүүлсэн Сонгуулийн тухай хуулийн төслийг энэ хуульдаа бүрэн тусгахыг аль болохоор төсөлд нэгтгэн тусгасан. Тийм учраас горимын саналыг хураалгаж өгөөч гээд танд би горимын саналын томъёоллыг өгсөн байгаа. Тэр томъёоллын дагуу таныг горимын санал хураалгаж өгөхийг хүсье. Ийм санал байгаа юм Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын гишүүдээс өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг суурилан Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл нарын гишүүдээс өргөн мэдүүлсэн Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалтыг нэгтгэсэн төсөлд бүрэн тусгасан бөгөөд зөвшөөрч байгаа эсэх талаар горимын санал хураалгаж өгөөч гэж байгаа юм.

Н.Энхболд: Хуулиудын төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэх үеэр хууль санаачлагчаас зөвшөөрлийг нь авсан. Тэрний дагуу Их Хурлын даргын захирамж гарсан байгаа. Тэгэхдээ дэгийн дагуу горимын саналаар санал хураалгах ёстой. Саяын Тогтохсүрэн гишүүний гаргасан горимын саналыг буюу 2 хуулийг нэгтгэж хамтран хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүнээс 7 дэмжиж 53,8 хувиар хамтарч хамтарч, хамтатган нэгтгэж хэлэлцэхийг зөвшөөрлөө.

Хуулийн төслүүдээ зүйл бүрээр хэлэлцэж эхэлнэ. Та бүхэнд зарчмын зөрүүтэй саналуудын томъёолол тараасан байгаа. 1 дүгээр зүйлийг хэлэлцэнэ. Ажлын хэсгээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналууд байна. Энэ саналуудаар санал хурааж эхэлье. Бэлэн үү гишүүд? Төслийн.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хасах:

“1/4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг:

4.3.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 126 гишүүнийг дараах байдлаар сонгоно:

4.3.1.Улсын Их Хурлын 78 гишүүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос олныг төлөөлөх /мажоритар/ аргаар;

Тайлбар: “олныг төлөөлөх /мажоритар/ арга” гэж тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү бөгөөд хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.

4.3.2. Улсын Их Хурлын 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорциональ/ аргаар.”

Тайлбар: “хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорциональ/ арга” гэж сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн авсан саналынх нь тоо, хувьд үндэслэн энэ хуульд заасны дагуу суудал хуваарилж, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Бат-Амгалан, Баттөмөр, Ганибал, Доржханд, Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Одонтуяа, Пүрэвдорж, Сарангэрэл, Туваан, Энх-Амгалан, Энхбаяр цаашид ажлын хэсэг гэнэ. Ажлын хэсгийн гишүүн юу асуух гээд байна вэ? Сарангэрэл гишүүний.

Д.Сарангэрэл: Тогтохсүрэн даргаа энэ 4.3.1 дээр энэ хуульд заасны дагуу байгуулагдсан тойрог гэж энд энэ байгаа юм уу? Энэ хуульд тийм тойргоо. За. Байгуулаагүй байгаа тийм ээ? За.

Н.Энхболд: Болсон уу? Санал хураалт сая томъёоллоо уншсан нэг дэх санал, санал хураалт. 7 гишүүн дэмжиж 58,3 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт, мөн зүйлийн 16 дахь заалтыг нэгтгэн 1 дүгээр зүйлийн 19 дэх заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дугаар зүйлийн 5 дахь заалтыг хасах:

“19/20 дугаар зүйлийн 20.22 дахь хэсэг:

20.22.Гадаад улсад байгаа иргэн гадаадад санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө сонгуульд оролцохоо мэдэгдэж, бүртгүүлнэ. Ажлын

хэсгийн санал. Санал хураалт. Туваан гишүүнээ санал хураалт, биш билүү? Ажлын хэсгийн гишүүн билүү? Уучлаарай. 7 гишүүн дэмжиж 58,3 хувиар санал дэмжигдлээ. Сая орж ирээд гарсан юмсан уг нь.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.4.4 дэх заалт, 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.6-7.10 дахь хэсгийг хасах. Ажлын хэсгийн санал. Санал хураалт. 7 гишүүн дэмжиж 63,6 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалтыг хасах:

“7/9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг:

9.3.Гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдөр /цаашид “гадаадад санал авах өдөр” гэх/-ийг сонгуулийн төв байгууллага /цаашид “Сонгуулийн ерөнхий хороо” гэх/-ын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоох бөгөөд гадаадад санал авах өдөр нь дөрөв хүртэл өдөр байна.” Ажлын хэсгийн санал. Дэмжье, санал хураалт. 7 гишүүн 63,6 хувиар саналыг дэмжлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 11.2 дахь хэсгийг хасах. Ажлын хэсгийн санал. Дэмжье санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдэж байна.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 10, 11 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10/11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг:

11.4.Улсын Их Хурлын гишүүнийг энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар сонгох сонгуульд Монгол Улсын нутаг дэвсгэр сонгуулийн нэг тойрог байна.” Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт. Тийм нөгөө жагсаалтын

жагсаалтаа тийм. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 12, 13 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

12.2.Энэ хуулийн 4.6-д заасны дагуу ээлжит бус сонгууль явуулах тохиолдолд Улсын Их Хурал ээлжит бус сонгуулийн санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө энэ хуульд нийцүүлэн сонгуулийн тойргийг байгуулна.” Ажлын хэсгийн санал дэмжье санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 19¹ дүгээр зүйлийн 19¹.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“19¹.3.Төв комиссын дарга дотоод ажлын асуудлаар захирамж гаргана.” Ажлын хэсгийн саналыг дэмжье санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтын 19¹ дүгээр зүйлийн гарчгийн “бүрэн эрх,” гэснийг хасаж, 19¹.7 дахь хэсгийн “эрхийг” гэснийг “чиг үүргийг” гэж, 19¹.7.10 дахь заалтын “эрх” гэснийг “чиг үүрэг” гэж, 19¹.7.2 дахь заалтын “сахин биелүүлэх явдлыг хангах” гэснийг “хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах” гэж тус тус өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 63.6 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.16 дахь хэсгийн “танилцах” гэсний дараа “, ашиглах” гэж нэмэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. Танилцах гэсний дараа таслал ашиглах гэж нэмэх юм байна шүү. 72,7 хувиар дэмжигдлээ.

11.Төслийн 1 дүгээр зүйлийн 19 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.18 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 2 дугаар зүйлийн 6 дахь заалтыг хасах:

“19/20 дугаар зүйлийн 20.21 дэх хэсэг:

20.21.Энэ хуульд заасан журмын дагуу Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, төрийн бус байгууллагын төлөөлөл сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаатай танилцаж нягтлах эрхтэй.” Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдэж байна.

12.Төслийн 1 дүгээр зүйлийн 20 дахь заалт буюу 23.8 дахь хэсгийн “улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас” гэснийг “холбогдох байгууллагаас” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдэж байна.

13.Төслийн 24 дэх заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

24/29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэг:

“29.10.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөлөл, оролцоог хангаж, тэгш боломж олгоно.” Ажлын хэсгийн саналыг. Асуулт, санал байна. Сарангэрэл микрофон өгье.

Д.Сарангэрэл: Хуулийн төслийн энэ 29.10-д төгсгөлд нь тэгш боломж олгоно гэж гэдгийг хасаад, энэ тэгш боломж олгох ер нь юугүй юм байна лээ лээ боломжгүй юм байна лээ л дээ. Тийм бүх хүнд тэгш боломж олгоно гэж байхгүй. Тэгэхээр зүгээр төлөөлөл оролцоог нь хангах гэж гээд энэ тэгш

боломжийг хасах санал оруулж байна даргаа. Тийм.

Н.Энхболд: Саналаа хураачихъя. Байнгын хорооноос чиглэл өгчихье редакцияар засаад эсхүл тэгье редакцияар нь засаж болох юм байна.

Д.Сарангэрэл: Тэгье.

Н.Энхболд: Санал хураалт. Найруулгаа үгээ хараарай тийм ээ. Хангана. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 1 дүгээр зүйлийн 27 дахь заалт буюу 33.1.10 дахь заалтын “дэвшигчийг” гэсний дараа 29.7-д заасныг зөрчсөн бол тухайн нэр дэвшигчийг” гэж нэмэх.

“48.1.8.тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх, амлалт өгөх, зарлах.” Санал хураалт. Ажлын хэсгийн санал.

15.Төслийн 1 дүгээр зүйлийн 28 дахь заалт буюу 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсгийн “хэмжээнээс” гэснийг “хэмжээний 50 хувиас” гэж өөрчлөх. Ажлын хэсэг. Саналыг дэмжье, санал хураалт. 63.6 хувиар, Батсуурь гишүүн үлдчихсэн байна шүү. Санал дэмжигдлээ.

16.Төслийн 1 дүгээр зүйлийн 29 дэх заалтын 38.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.13.Төрийн аудитын дээд байгууллага нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн энэ хуулийн 38.5-д заасан мөрийн хөтөлбөр, 38.7-д заасан хандивын тайланд тус бүр нэг дүгнэлт гаргана. Хандивын тайлан нь ээлжит жилийн, ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааг, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацааг хамаарна.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье.

Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 1 дүгээр зүйлийн 31 дэх заалтын 41.16 болон 41.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.16.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь тухайн нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг эрхлэн явуулна.

41.17.Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь гурван хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй байна.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжиж санал хураалт явуулъя. 81,8 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 1 дүгээр зүйлийн 33 дахь заалт буюу 47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32/47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсэг:

47.12.Жагсаалтаар нэр дэвшигчийн цахим орчин дахь сонгуулийн сурталчилгааг нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага энэ хуульд заасны дагуу бүртгүүлсэн цахим хуудсаар эрхлэн явуулна. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахад энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхийг хориглоно.” Оюунчимэг дараа нь, Оюунчимэг гишүүнийх.

М.Оюунчимэг: 1 дүгээрт яг сая хэлсэн тэр дээд хэмжээний 15 хувиас хэтэрхийг хориглоно гэдгийг бол арай хатуу заалт байна. Тэгэхээр энэ дээр бас үгэн дээр, найруулга 2 дээр бол анхаарах нь зүйтэй юм болов уу гэсэн нэгд бодолтой байна.

2-т нь саяхан СЕХ-ноос тэгсэн үү, хаанаас тэгсэн энэ намын нэрийн жагсаалтад нэр дэвшигчдийг бүгдийг нь бичих ямар ч бололцоо байхгүй. Тийм

учраас зөвхөн нам дугуйлна гээд мэдээлэл өгөөд байна лээ. Тэгэхээр энэ иргэд чинь хэдийгээр намын нэрийн жагсаалтаар нам, намын нэр байна, намын нэрийн цаана бас ямар хүн байгаа вэ гэдгийг мэдэх хэрэгтэй. Энийг мэдмээр байна гээд байгаа шүү дээ. Тэгэхээр яаж бид нар энийг зохион байгуулах вэ? Тэгээд энэ дээр нэг хариулт авчихъя. Яагаад гэвэл бас хэнийг дугуйлж байгаагаа энэ нам гэдгийн ард нэр дэвшигчдийн нэрс нь тодорхой болгох нь их чухал гэж үзээд байгаа. Тэгэхээр энийг яаж зохицуулж байгаа вэ?

Н.Энхболд: Ийм зохицуулалт байгаа. Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн хариулна. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Нэрсийн жагсаалтаар намын нэрсийн жагсаалтаар, нам эвслийн нэрсийн жагсаалтаар нэр дэвшиж байгаа хүмүүсийн сонгуулийн сурталчилгааг зөвхөн намын байгууллага нь, нам юм уу эвсэл нь хийнэ 1 дүгээрт нь ийм зарчимтай байгаа.

2 дахь нь бол өмнө нь бол нөгөө сурталчилгаа хийхийг хориглодог байсан. Одоо бол нэгдсэн сурталчилгаа хийхийг нээж өгсөн байгаа. Тэр байтугай нэгдсэн хэвлэх материал 3 хуудаснаас хэтрүүлэхгүйгээр хийхээр байгаа. Тэгээд одоо энэ таны яриад байгаа энэ 47.12 дахь заалт нь бол цахим сурталчилгааг нь зохицуулж өгч байгаа юм. Тийм цахим сурталчилгаа хийнэ. Тэгэхдээ энэний зардлын хэмжээ нь нөгөө нийт зардлын хэмжээнийхээ 15-аас хэтрэхгүй гэдэг ийм заалт байгаа юм. Тэгэхээр бол нөгөө энэ намын нэрсийн жагсаалтаар нэр дэвшиж байгаа хүмүүсийн хувьд бол нам эвсэл нь зохион байгуулаад сурталчилгааг нь болон бусад арга хэмжээг зохион байгуулахыг нь бүгдийг нь хуульд зурагт хуудас нь ямар байх вэ, телевизийн сурталчилгаа ямар байх вэ, цахим сурталчилгаа ямар байх вэ, хэвлэмэл сурталчилгаа ямар байх вэ гэсэн сурталчилгаануудыг бүгдийг нь зохицуулалт хийж өгсөн байгаа. Тийм учраас тэр хүмүүсийг сурталчилгаа

хийж, сурталчилж танилцуулна гэдгийг хуулиар зохицуулж өгч байгаа.

Н.Энхболд: Баярлалаа. Энэ юугаа дээд хэмжээний 15-аас хэтрэхгүй байна л гэхивэл яасан юм бэ дээ. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээ нь 15-аас хэтрэхгүй байна гээд л явчихъя. Тийм тэр нь угаасаа 51 дээр нийт зардал нь гээд байж байгаа. Санал хураалт явуулъя. Нэрс бол нээлттэй байна шүү дээ. Бүгдийг нь зурагтай нь, нэртэй устай нь өгчихнө, тийм. 72,7 хувиар энэ санал дэмжигдлээ.

19.Төслийн 1 дүгээр зүйлийн 34 дэх заалт буюу 48 дугаар зүйлийн 48.1.8-48.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34/48 дугаар зүйлийн 48.1.8 дахь заалт:

48.1.8.тухай жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх, амлалт өгөх, зарлах.” Энэ нөгөө хориглох зүйл дээр явж байгаа юм байна. Санал хураалт, ажлын хэсэг. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 1 дүгээр зүйлийн 35 дахь заалт буюу 48 дугаар зүйлийн 48.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34/48 дугаар зүйлийн 48.10 дахь хэсэг:

48.10.Радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлэхийг хориглоно.” Ажлын хэсгийн саналыг дэмжье, санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ. Сарангэрэл гишүүн микрофоныг нь өгчих.

Д.Сарангэрэл: Сая Энхболд даргаа бид нар 48.10-ыг дэмжлээ. Би ч гэсэн дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ зөвхөн радио телевизээс бусад юмаар явж болно гэдэг ийм агуулга яваад байгаа байхгүй юу.

Н.Энхболд: Ажлын хэсэг дээр юу гэж ярьсан юм бэ энийг?

Д.Сарангэрэл: Тэрийг харин яриагүй л юм байна. Сая харсан чинь ерөөсөө хоёрхон хэвлэл мэдээллийн хэрэгслийг тодотгоод, өөр юунууд сайт зөндөө байгаа дарга. Тэгэхээр нөгөө юуны сошиал орчны телевиз байгаа тэрүүгээр болно гэсэн үг үү гээд. Энэ зөвхөн нөгөө эфирийн 2-ыг нь юу яагаад л бусдыг нь үлдээчихсэн байгаа байхгүй юу. Бусад нь нээлттэй байна гэсэн үг болчихоод байгаа байхгүй юу. Тийм та нар маань энийг юу гэж бодож байна вэ?

Н.Энхболд: Лувсан-Очир дарга нэг тайлбар хэлэх үү. Хэддүгээр микрофон байна вэ, 3 дээр очоод суучих Лувсан-Очир. 3, 4 хоёрын нэг дээр, эмэгтэй хүмүүсийн сандал булааж авах нь дээ. Хариулах хүмүүс дугаартай микрофонууд дээр суугаад хариулаарай.

А.Лувсан-Очир: ХХЗХ Лувсан-Очир. Сая 48.10 дээр бол радио, телевиз гэдэг ойлголт бол 1 дүгээрт нөгөө тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийг бол ойлгож байгаа. Цахим орчинд шууд дамжуулалт хийдэг нөгөө live хийдэг бичлэг оруулж байгаа энэ тэр бол Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар бол ямар нэгэн тусгай зөвшөөрөл авдаггүй байгаа. Тэгэхээр радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх харилцаа Сонгуулийн хуулийн 46 дугаар зүйлээр бол бүхэлдээ зохицуулагддаг. Тэгэхээр ХХЗХ-ноос тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн болон арилжааны радио телевизийн асуудал бол энд хамаарч байгаа. Төлбөргүй нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаа бол МҮОНРТ-ийн дамжуулах тэр хэсэгт бол хамаардаг.

Цахим орчин дахь шууд дамжуулах, live хийх, page хуудсаар бичлэг түгээх энэ харилцаа бол Сонгуулийн хуулийн 47 дугаар харилцаа дээр бол тогтсон байдаг. Тийм. Нэр дэвшигч бол 3 төрлийн цахим хуудсыг бол сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш 3 хоногийн дотор бүртгүүлнэ. Түүний нэг нь бол олон нийтийн, олон нийтийн сүлжээний цахим хуудсыг бүртгүүлэхээр хуульчилсан байж байгаа. Тэр заалтууд бол хүчин төгөлдөр хөндөгдөөгүй байгаад байгаа. Тийм, хуулийн 47.1 дээр болохоор цахим хуудсаар бол 3 төрлийн цахим хуудсаар сонгуулийн сурталчилгааг бол нэр дэвшигч явуулах эрхтэй. Нэг нь бол нам эвслийн веб хуудас, нөгөөдөх нь болохоор нэр дэвшигчийн өөрийнх нь олон нийтийн сүлжээний page хуудас, 3 дахь нь бусад цахим хуудас гэгчихсэн байгаа. Тэр нь мэдээ мэдээллийн. Тухайлбал Ikon. GOGO ч гэдэг юм уу ийм цахим хуудаснуудыг тодорхойлж өгсөн байгаа. Энийгээ, тийм. 47 дугаар зүйлийн 9 дээр бас цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулах харилцааг бас зохицуулсан журмыг батлах гэж байгаа. Тэр журам дээр бол сонгуулийн сурталчилгааны live дамжуулах page хуудаснууд бол бас бүртгүүлэх тусгай форумар бүртгүүлэх тэр харилцааг зохицуулж өгсөн байгаа. Баярлалаа.

Н.Энхболд: Ер нь зүгээр ингэж, одоо жишээ нь хувь хүн өөрийнхөө facebook-ээр тийм ээ хаягаар янз бүрийн аль нэг нэр дэвшигчийг тусгайлан сурталчилсан байдаг юм уу тийм юм хийгээд байвал яаж зохицуулах вэ? 3 дугаар микрофон өгөөдөх.

А.Лувсан-Очир: Тийм, хувь хүмүүсийн зүгээр иргэдийн өөрсдийнх нь цахим хуудас бол цахим хуудсаар сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлж байгаа мэдээлэл бол иргэд үзэл бодлоо илэрхийлж байна гэж бол үзэж байгаа. Тэрийг бол яг Сонгуулийн хуулиар бол зохицуулсан харилцаа байхгүй.

Н.Энхболд: Энэ анхаарах ёстой сэдэв, асуух ёстой асуулт мөн. Саналаа

хураачихъя юу ч гэсэн радио телевизтэй холбоотой хураачихсан сая тийм ээ.

21. Төслийн 1 дүгээр зүйлийн 37 дахь заалт буюу 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37/53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэг:

53.4.Энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.” Ажлын хэсгийн санал. Санал хураалт, бууна. Горимын санал гаргачих. Сарангэрэл гишүүний микрофоныг өгье, Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Сая саяын санал хураалт дээр техникийн саатал гараад би эсэргүүцсэнээр гарчихлаа.

Н.Энхболд: Сүхбаатар, санал хураах гэж байна шүү дээ.

Д.Сарангэрэл: Саяын саналыг хүчингүй болгоод дахин санал хурааж өгнө үү.

Н.Энхболд: Хэдэн хүн байна вэ? Бүгдээрээ дэмжвэл болох юм байна. Сарангэрэл гишүүний гаргасан горимын саналыг дэмжье. Энийг хүчингүй болгох санал түрүүчийн санал хураалтыг. Санал хураалт, хээ нь арилчихсан байгаа хурууны. Энэ ирц болохгүй байна даа. Уучлаарай, саяын саналыг хүчингүйд тооцох санал гаргаж байна. Би юм ярьж байгаад өөрөө хоцорчихжээ. Миний энэ саналыг дэмжиж өгөхийг хүсье, хүчингүй болгох санал. Анхааралтай байгаарай. 54,5 хувиар түрүүчийн саналыг хүчингүй болголоо. Дахиад 21 дүгээр саналаа уншсан томьёоллын дагуу дэмжье гэсэн санал хураалт явуулья. 54,5 хувиар дэмжигдлээ.

22 Төслийн 1 дүгээр зүйлийн 38, 39 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37/59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг:

59.4.Саналын хуудас нь дараах хэсэгтэй байна.

59.4.1.энэ хуулийн 4.3.1-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшигчид санал тэмдэглэх;

59.4.2.энэ хуулийн 4.3.2-т заасан нам, эвсэлд санал тэмдэглэх.” Ажлын хэсэг. Тийм, санал хураалт. Аль алийг, энэ үү? Энэ уг нь урьдчилсан санал авахтай холбогдсон заалт байсан юм. Тэгээд хасах гэдэг нь юу яачхаж 43-ын 41-ийн энэ заалт нь хаана байна вэ? Үгүй ээ энэ бичээгүй байна, зүгээр энэ дугаараар нь тавьчихаж уншаадахъя. Урьдчилан санах санал авах ажиллагаа гэсэн 63¹ дүгээр зүйл байгаа юм. Хасъя гэж байгаа санал нь. Тэр нь юу гэж байгаа вэ гэхээр 1 дүгээрт санал 63¹.санал авах өдөр, санал хураах, санал авах байранд өөрийн биеэр саналаа өгөх боломжгүй сонгогч санал авах өдрийг хүртэлх 5 хоногийн хугацаанд санал авах байранд урьдчилан саналаа өгч болно. 63¹.2.урьдчилсан санал авах ажиллагааг санал авах байранд 9-өөс 17 цагийн хооронд зохион байгуулна. 63¹.3 сонгогч санал тэмдэглэх зааврын дагуу саналаа тэмдэглэж, саналын хуудсаа битүүмжилсэн саналын хайрцагт хийнэ. 63¹.4-д урьдчилсан санал авах ажиллагаанд энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгогч санал авах байранд саналаа өгөх журмыг баримтална гэсэн ийм заалт байгаа юм. Тэгэхээр ажлын хэсгээс зүгээр тайлбар сонсчихё. Ямар үндэслэлээр яаж хэлэлцэж байгаад хасах санал оруулж ирэв гээд. Тогтохсүрэн гишүүнийг, Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ 63¹ дэх заалт бол сонгогч санал хураах

өдрөөс өмнө 5 хоногийн хугацаанд урьдчилсан санал өгч болно гэдэг ийм заалт байгаа юм. 2008 оны сонгуулиас өмнө энийг хэрэглэж ирсэн юм байна лээ, 8 оноос өмнө сонгогч өгч байсан. 8 оноос хойш өгч байгаагүй юм байна лээ. Ажлын хэсэг дээр энийг яагаад хасах ч болов гэхээр 1 дүгээрт энэ сонгуулийн будилаанаас будилаан үүсэхээс бид нар аль болохоор зайлсхийх ёстой гэдэг ийм асуудал байгаа юм. Тэгээд 2008 оны сонгууль нэлээн их будилаантай болсон. Тэгээд будилаантай болгох гэхэд олон үндэслэл байдаг. Тэгээд санал тоолох, тэгээд нөгөө урьдчилсан саналууд, царцаанууд эд нар гээд их олон хүчин зүйлүүд байдаг юм байна лээ. Тэгээд тэр 8 оны сонгуулиас хойш бол нөгөө хар машин нь хэрэглэж сонгуулиа автоматаар тоолдог болоод, энэ удирдсан санал хураалтыг болиод, шилжилт хөдөлгөөнүүдийг зогсоогоод нөгөө царцаануудыг гэсэн үг шүү дээ. Ингээд явснаас хойш бол сонгууль харьцангуй будилаангүй, сонгогчид болон улс төрийн намууд сонгуулийн үр дүнгээ хүлээн зөвшөөрдөг ийм байсан байна.

Ийм учраас болбол энэ яах вэ нэг талаасаа бол энэ сонгогчдынхоо саналыг авч сонгогчид төр барих эрх эрхийг нь Үндсэн хуулиар олгогдсон эрхийг нь хангах сайн талтай боловчиг энэ жижижхэн цонхоор сонгуулийн будилаан гарах эх үүсвэрийг бий болгочхож магадгүй гэдэг байдлаар ажлын хэсгийн гишүүд ярилцаж байж байгаад, манай Баттөмөрийн Энхбаяр гишүүнээс эхлээд бүүр кэйсүүд хүртэл энэ дээр ярьсан. Сонгуулийн тодорхой кейсүүд. Ийм учраас ингэж ярилцаар байгаад бид нар энэ заалт ер нь байх шаардлагагүй юм. Сүүлийн 3 удаагийн сонгууль дээр энэ асуудлыг хэрэглээгүй яваад ерөнхийд нь Монгол даяараа ийм урьдчилсан санал хураалтгүйгээр явдаг жишиг тогтчихсон учраас эргэж буцаж орох шаардлагагүй юм гэж үзээд энэ саналыг хасахаар ажлын хэсэг шийдвэрлэсэн юм.

Н.Энхболд: Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Тэр хэний Тогтохсүрэн даргын тэр хэлээд байгаа тайлбар нэг талдаа үнэн. Тэгээд нөгөө нэг л асуудал үүсчхээд байгаа юм, үүсдэг юм байна лээ будилаан. Тэр нь юу вэ гэхээр яг одоогийн энэ тохиолдолд бол гадаадад жишээлбэл ингээд явах гэж байгаа хүний цаг хугацааны хувьд ингээд таарчихдаг. Дотоодод ч гэсэн өөр тэр тал руу очоод ингээд хуучин бол яах вэ зорчих, нөгөө сонгогчдын шилжилт хөдөлгөөн бол тойрог дотроо бол яах вэ болдог. Тэгээд л нөгөө хүн өөр газар луу очиход тэр зөвшөөрөгдөхгүй ч гэдэг юм уу. Одоо бол томсгосон нөгөө нам эвслийн төлөө өгч байгаа бол бас байж болохоор ч гэдэг юм уу ингээд. Тэгэхээр нөгөө сонгогчийн эрх талаасаа зүгээр энэ зөрчигдөж байна гэдэг асуудал л босож ирэх дараа нь магадлалтай.

2 дугаарт ер нь бол дэлхийн улс орнуудын хандлага бол урьдчилсан санал хураалтуудад бол ер нь бол нэг их хумигдахгүй, одоо ингээд харахад. Жишээлбэл сая Америк бол шуудангаар өгөөд гэдэг юм уу энэ чинь бол хавтгайдаа явчихсан шүү дээ. Одоо тэрийгээ ч нэг их яг больё ч гэж байгаа юм байхгүй л. Ер нь тэр сонгуулийн байгууллагуудын нэг явж байгаа юм бол сонгогчийн эрхээ аль болохоор хангах ёстой гэдэг тэр чиглэл рүү л явах ёстой л болчихно л доо. Зүгээр яах вэ сонгуулийн зохион байгуулалт хэл амгүй, будилаангүй гэдэг талаасаа бол ингээд явчих нь бол ингээд хаана хаанаа зүгээр гэж байгаа ч гэсэн яг энэ завсар 100 эрх нь зөрчигдөх хэдэн зуу ч гэдэг юм уу, хэдэн мянган хүн ч гарч болно. Тэдний зүгээс бол энэ бол сонгогчийн эрхийг хязгаарлалаа л гэдэг асуудал үүсэх байх. Ер нь тэгэхдээ энийг бас нөгөө зөвшөөрөх тохиолдолд бол тодорхой үндэслэл шалтгаанаар тэрийгээ урьдчилж бүртгүүлэх тэр байдлаар ингээд хийх нь бол уг нь зүйтэй. Тэрнээс биш зүгээр ингээд хавтгайд нь Америкууд эд нар шиг ингээд тавьчих юм бол энэ чинь замбараагаа алдана л даа.

Сая чинь бол Америкийн сонгуулийг харахад бол бүүр ерөөсөө хавтгайдаа юм

байна лээ шүү дээ тэр чинь одоо өгч байгаа байдал нь урьдчилаад баахан хүн өгчихсөн. Тэрийгээ бараг нөгөө сонгуулийн үйл ажиллагааг хялбаршуулж, сонгогчийн эрхийг хангаж байгаа ийм ажил гээд сонгуулийн санал хураалт эхлэхээс өмнө бараг энэ чинь зарим нь 20, 30 хувь нь өгчихсөн байсан шүү дээ тэр юун дээр харахаар. Тэгэхээр яах вэ энэ бол манайд зүгээр ийм шударга сонгуулийн асуудал яригддаг бас эргэлзээтэй байдаг үед болгоомжлол эд нар бол байна л даа. Тэгэхдээ энийгээ зүгээр бид бас тэрийгээ л бодох асуудал байгаад байгаа.

Ер нь бол нэр томъёогоо бас бодмоор юм байна шүү. Түрүүн тэр 22 дугаар санал дээр сонгуулийн тойрогт нэр дэвшигчид санал тэмдэглэх гээд энэ чинь хэл хугарчихаар ерөөсөө тийм буруу тийм нэр томъёолууд явж байна шүү дээ. Сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн төлөө өгсөн саналыг тэмдэглэх гэдэг ч юм уу ингээд Монгол хэлийнхээ найруулга зүйн талаасаа юм бодохгүй бол нэр дэвшигчийн санал тэмдэглэх гэхээр энэ чинь юу гэсэн ч утгатай үг юм. Тийм ээ. Энэ чинь ойлгогдохгүй юм байна шүү дээ. Хэний төлөө өгсөн саналыг тэмдэглэх гээд байгаа юм. Тэр нэг үгийн Монгол хэлний үг байна шүү дээ. Тэрийг нь зүгээр бас давхар бас хэлчихье. Найруулгын асуудал бол ер нь гарч ирэх юм байна шүү. Би бол яг үнэнийг хэлэхэд нөгөө өөр юмнууд дээр ажиллаад, Сонгуулийн хууль дээр бол яг ажиллаж чадахгүй л байна л даа. Тэгэхээр зүгээр ингээд харахад саяын тэр хэлдэг тайлбараа сонгууль зохион байгуулалттай болгохын тулд хасчихсан гэж ярих юм бол сонгуулийн эрхийн талаасаа яг наад үгээр чинь бол Цэц дээр очиход бол Тогтохсүрэн даргын тэр хэлсэн тайлбараар бол шууд хүчингүй л болох заалтаар Үндсэн хууль зөрчсөн гээд л үндэслэл болчихно л доо. Тэгэхээр энийг нь бас бодож, дундуур нь бас давхар бас ажлын хэсэг бас гаргалгаануудаа бодохгүй бол сонгуулийн зохион байгуулалтын талаасаа хялбар болгох гэсэн гэдэг өгүүлбэр бол сонгогчийн эрхэд бол шууд цохиулаад үндэслэл болж

чадахгүй болно шүү гэдэг бас нэг тийм юм байгаа.

Тэрийгээ зүгээр хийвэл ийм 2 тохиолдолд үндэслэл шалтгаанаа урьдчилж ингэж бүртгүүлсэн сонгогч урьдчилсан санал өгч болно ч гэдэг юм уу ингэж нөгөө зөврийн хайрцагар гэдэг шиг. Ер нь бол яах вэ зөврийн хайрцаг урьдчилсан санал хураалт 2 дээр бол будилаан үүсгэж ашигладаг явдал бол гардаг тэр бол үнэн. Гэхдээ энэ бол сонгуулийн зохион байгуулалтын л асуудал талаасаа ярьж байна. Тийм.

Н.Энхболд: Яах вэ, хууль санаачлах, ер нь энэ бид нарын өргөн барьсан хууль дээр байсан санал байгаа юм. Надад бол ажлын хэсэг дээр яригдсан зүйл бас үндэслэлтэй л санагдаж байна нэгд. Зүгээр хүний эрх гэдэг талаасаа нэг талаас нөгөө талаас сонгуулийн дараа бас үр дүн хүлээн зөвшөөрөгдөх талаасаа бодоод үзвэл аль болохоор замбараатай, ямар нэгэн тийм боломж байвал сонгогчид ашиглаад тэр нь эцсийн дүндээ сонгуулийн үр дүнд нөлөөлөхөөр хэмжээний юм болчихвол бас онцгүй л юм байгаа юм. Ямар ч байсан ажлын хэсгийн саналаа дэмжье гэсэн санал хураалт явуулья. Би хууль санаачлагчийн хувьд энэ саналыг дэмжиж байгаа шүү дээ. Санал хураалт. Саналаа. 63,6 хувиар дэмжигдлээ. Тэр давхар бодсон юмнуудаа бас энд тэнд тусгахыг бодоорой. Сүхбаатар гишүүний хэлсэн тэр саналыг та нар найруулга дээрээ аваад, өгсөн саналыг тэмдэглэх нам эвсэлд өгсөн саналыг тэмдэглэх гэсэн найруулгаар явчхаарай. Тийм 4.1, 4.2 дээр.

24.Төслийн 1 дүгээр зүйлийн 42 дахь заалт буюу 64¹ дүгээр зүйлийн 64¹.1 дэх хэсгийн “Сонгуулийн ерөнхий хорооноос” гэснийг “энэ хуульд заасны дагуу” гэж өөрчлөхөөр ажлын хэсгээс гаргасан саналыг дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

25.Төслийн 1 дүгээр зүйлийн 43 дахь заалт буюу 65 дугаар зүйлийн 65.16,

65.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“65.16. Сонгогчийн нэрийн жагсаалтын нэгдсэн санд бүртгэлийн хуудас авсан сонгогчийг ялгах тэмдэглэгээ хийнэ.

65.17. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 65.6-д заасан сонгогчийн гарын хурууны хээгээр сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай тулган таниулах үйл ажиллагааг хариуцна.”
Ажлын хэсгийн санал. Батсуурь гишүүн. Батсуурь гишүүний микрофоныг.

Ж.Батсуурь: Энэ дээр санал өгсөн сонгогчид болон сонгогчдын нэрсийн жагсаалтад нэгдсэн санд ялгах тэмдэглэгээ хийнэ гэж байна. Тэгэхээр нэгдсэн сан энэ хуулийг хэд дээр орсон бэ 1 дүгээрт? Хоёрт, болоогүй байна шүү. Тэгээд нэгдсэн сан гэдэг нь жишээлбэл Ховд аймагт өгсөн санал өгсөн хүн өөр хаана ч байдаг юм Улаанбаатар хотод юм уу, Өмнөговь аймагт өгөхөд нэр зургаар, зургаар буюу хурууны хээгээр өгөхөд бол тэр offline болсон байна гэсэн үг үү? 1 дүгээрт.

2 дугаарт хурууны хээ болон царайг тулган таниулах ажиллагааг сонгогчийн нэрсийн жагсаалтын нэгдсэн сангаас хийх нөхцөл боломжийг Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцах бөгөөд Ерөнхий хороо тагнуулын байгууллага хяналт тавина гээд байх юм. Миний ойлгож байгаагаар Сонгуулийн хороо нь хариуцахгүй юм уу?

Н.Энхболд: Бүртгэлийн газраас хэн байсан билээ?

Ж.Батсуурь: Хариулт авъя, тэгээд тодруулъя.

Н.Энхболд: Хариулъя хэддүгээр микрофон дээр, нэрээ хэлээд тийм. Нэгдсэн сан Ховдод өгчихсөн байхад өөр газар гарах уу, яаж тулгаж шалгадаг

талаар асуусан. 3 дугаар микрофон өгье ажлын хэсгийн.

Б.Наранцэцэг: УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газар Наранцэцэг асуултад хариулъя. Сонгогчдын нэгдсэн сантай байх асуудал бол хуулийн 20.14 дүгээр зүйл дээр бол зохицуулагдсан байгаа. Энэ зүйлтэй холбоотойгоор сонгогч хэрвээ сонгогч орж ирээд сонгогчийн бүртгэлд бүртгүүлээд сонгогчийн бүртгэлийн хуудас авсан тохиолдолд энэ сонгогчийг бол тухайн үед бол бид нар сонгогчийн бүртгэл сонгогчийн санал өгсөн бүртгэл рүү ордог байсан. Одоо бол энэ хуулийн зохицуулалт орж ирснээрээ сонгогчийн нэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн санд тухайн сонгогчийг санал өгсөн эсэхийг бол яллах тэмдэглэгээг бол хийдэх, хийгдэхээр зохицуулагдсан.

Өнөөдрийн таны асуусан асуултаар Баянхонгорт байж байгаа хүн тэнд нөгөө хэсэгт очоод бас санал өгчих боломжтой юу гэхэд энэ бол тийм боломж байхгүй. Үүнтэй холбоотойгоор нөгөө сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах, одоо юуг нь давхардал зөрчил байгаа эсэхийг нягтлан шалгах гээд энэ бүх процессуудыг бол энэ хуулиар бас зохицуулж өгсөн байж байгаа. Тухайлбал сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгахдаа хэн нягтлан шалгах юм, үүн дээр ямар байгууллага хяналт тавьж ажиллах юм, ямар журмаар хяналт, ямар журмаар энийг нягтлан шалгах юм бэ гэдэг асуудлыг бол энэ хуульд бол тусгайлан бас зохицуулж өгсөн байгаа.

Н.Энхболд: Батсуурь гишүүний микрофон өгье.

Ж.Батсуурь: Энэ сонгогчийн нэрсийн жагсаалтын санд бүртгэсэн хуудас авсан сонгогчийн ялгах тэмдэглэгээ хийнэ гэж байна л даа. Би энийг сайн ойлгож өгөхгүй л байна л даа 1 дүгээрт.

Аймаг хооронд байхгүй юм байна. Тэгвэл ер нь хот дотроо ч гэсэн хуучин царцаа гэж ярьдаг шүү дээ. Энэ царцааны асуудал бол үндсэндээ бүрэн шийдвэрлэгдсэн гэж ойлгож болох уу? Онлайн.

Н.Энхболд: 3 дугаар микрофон, 3 дугаар микрофон өгөөрэй.

Б.Наранцэцэг: Энэ санал өөрөө орж ирэхдээ нөгөө АН-аас орж ирсэн санал. Эд нар, уучлаарай.

Н.Энхболд: Хариултаа сонсъё Батсуурь гишүүнээ.

Б.Наранцэцэг: Уучлаарай. Яах вэ нөгөө томъёолол нь ингэж орж ирсэн болохоор л тэрийг нь.../үг тасрав/

Н.Энхболд: Зөв, тийм зөв санал орж ирсэн байсан гэж хэлэх гэж байгаа байлгүй дээ бодвол.

Б.Наранцэцэг: Яах вэ нөгөө томъёолол нь яг тухайн үед тэгж орж ирсэн болохоор нь би энийг ялгах тэмдэглэгээ гэдгээр нь хэлчихлээ л дээ. Тийм ялгах тэмдэглэгээ хийнэ гэж орж ирсэн юм.

Н.Энхболд: 3, 3 дугаар микрофон ялгаж чадаж байгаа гэдгээ микрофондоо хэлчих.

Б.Наранцэцэг: Тийм ялгаж чадаж байгаа. Санал өгсөн гэж нөгөө сонгогчийн бүртгэлийн хуудас авсан. Бүртгэлийн хуудас авсан гэдэг юм. Тийм.

Н.Энхболд: Ер нь бол найруулгын жишээ нь сонгуулийн бүртгэлийн хуудас авсан сонгогчийг нэгдсэн санд тэмдэглэнэ гэсэн л дахиж өөр газар давтагдахгүй л гэсэн санаа байна шүү дээ, тийм ээ?

Б.Наранцэцэг: Тийм.

Н.Энхболд: Тэрүүнийг найруулга дээрээ та нар жаахан анхаараарай, тийм. Энүүнийг ажлын хэсэг дээр

Тогтохсүрэн даргаа яг саяынхаа санаагаар янзлаад чуулганд оруулахдаа найруулга талаас нь эвтэйхэн болгочхоорой. Туваан гишүүнийхийг өгье, дараа нь Сүхбаатар гишүүн. Тийм нэг найруулга талаасаа харчих. Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ юу шүү дээ, одоо энэ дээр нэг ийм асуудал байгаа манайхан сайн сонсоод авчих. Энэ юу хэлж байна гэхээр сонгогч 2 сая 100 мянган сонгогч байгаа. Ховд аймгийн Мөст сумын юу гэдэг юм 1 дүгээр хэсгийн хороон дээр гэдэг юм уу тэндээс авахад offline байдлаар тэр хэсэгт нь өгсөн 2 мянган хуудаснаас биш нэгдсэн 2 сая 100 мянган хүний саналаас авах нөхцөл бүрдсэн үү л гэсэн утгатай асуулт байхгүй юу. Тэгэхээр энийг хэлэх гээд байгаа юм. Түүрүүн бид нар өчигдөр ажлын хэсэг дээр ярьсан. Тэр юу сүлжээ байхгүй тэрийг нэгдсэн байдлаар онлайн байдлаар авч чадахгүй газруудыг бол бүүр сүлжээ тавьж байгаад авъя гэдэг асуудал ярьсан шүү дээ. Тэгэхээр энэ байдал чинь хангагдаж байгаа юу гэдэг л асуулт байгаа юм.

Бид нарын өгсөн санал ч гэсэн энэ онлайн байдлаар авахгүй бол тэр 2 мянган хүний саналаас авчхаад нөгөө талын хажуу талын хэсэг дээр дахиад нэр нь орчихсон байж байгаад давхардаад өгөхөөр таньж гарч ирээд байгаа. Өөрөөр хэлбэл нөгөө царцааны асуудал. Сонгууль шударга болгох гэдэг асуудал дээр л яриад байгаа юм. Энэ талаараа тайлбар өгөөч л гэсэн юм.

Н.Энхболд: 3 дугаар микрофон, ажлын хэсгийн 3 дугаар микрофон, ассан байна шүү микрофон чинь.

Б.Наранцэцэг: Улсын бүртгэлийн байгууллага сонгуулийн тухай хуулиар ер нь сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, нягтлан шалгах, давхардал зөрчлийг арилгах гэсэн энэ чиг үүргийг бол хэрэгжүүлэн ажилладаг. Тэгэхээр яг өнөөдрийн хувьд бол сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэхдээ мэдээж хэрэг

сонгогч нэг сонгогчийг давхардахгүй байдлаар л сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх ийм л чиглэлийг манайх баримталж явж байгаа.

Тэгэхээр зэрэг нэгдсэн сан дээр бид нар сонгогчдын нэрийн жагсаалт бол Баянхонгор дээр байгаа нэрийн жагсаалтыг ахиад нөгөө Төв аймаг дээр ч юм уу, Говь-Алтай аймаг дээр ч юм уу тийм давхардах асуудал бол манай нэгдсэн нэрийн санд бол байхгүй, энэ жагсаалтад бол байхгүй л гэж хэлэх байна.

Н.Энхболд: Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Би бас энийг зүгээр тайлбарлаж өгье. Эд нар бол яах вэ энэ ийм юм аа Батсуурь гишүүнээ, Туваан гишүүнээ. 12 оны сонгууль хүртэл бол сонгогчдын нэрийн жагсаалтыг баг хорооны Засаг дарга гаргаад, манай сонгуулийн хэсгийн хороод энийг нийлүүлээд бичдэг. Өөрөөр хэлбэл ерөнхийдөө бол яг баг хорооны Засаг дарга гаргадаг нэртэй боловч сонгогчдын нэрийн жагсаалт гэдгийг бол сонгуулийн манайх хороод тухайн үеийн түр байгуулагдсан хороод гаргадаг байсан юм. Тэгээд баг хорооны дарга нь зарим баг хорооны дарга нь юу гэж ярьдаг байсан гэхээр цэгцэлж чадахгүй байсан ашгүй та нар цэгцэлж өгнө гэж хүлээдэг байсан юм. Өөрөөр хэлбэл тэр үед бол би түүхийг нь яагаад та нарт бас танин мэдэхүйн хувьд хэрэгтэй. 97 онд хэн Энхсайханы Засгийн газар бол улаан паспорт солих ажиллагаа явуулаад, тэгээд тэр паспорт солих ажиллагаа бүүр маш удаан олон жил сунжирсан. Тэгээд тэрнээс болоод бүртгэлийн юм задраад сонгуулийн хороод өөрсдөө хийдэг байсан. Тэгэхдээ сонгуулийн хороод нь бас намын төлөөллөөр бүрддэг байсан. Тэгээд тэрэн дээр аягүй их тийм улс төрийн тоглолтууд гардаг. Бие биеийгээ ингээд буруутгадаг, энэ сонгогчдын бүртгэл будилууллаа гэдэг байсан.

Энийг 2012 онд одоо байгаа энэ Энхболд дарга З.Энхболд Зандаахүүгийн

Энхболд байна. Бид хэд яриад Ардчилсан намын тухайн үеийн байж байгаагаас маш их хардлага байдаг тухайгаа ярьж байгаад тэгээд иргэний бүртгэл, сонгогчдын бүртгэл гэж 2 тусдаа байсныг ерөөсөө болиод иргэний бүртгэл дээр суурилсан сонгогчдын нэрийн жагсаалтын тогтолцоо руу оръё гээд ингээд 12 оны сонгуулиас хойш яг үнэндээ бол энэ зөрчилтэй олон жил яригдаж байсан сонгууль болгон дээр хардлага байсан алга болчихсон байхгүй юу энэ чинь. Яах вэ хааяа нэг сөхөж боргож ирдэг нь нэг хүн 2, 3 санал өгсөн гэж жаахан улс төржүүлж ярьдаг ч гэсэн тийм бололцоо тэр урьд өмнөх он жилүүд шиг юм бараг байхгүй болчихсон. Одоо бол бүр нарийсаад манай сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сан гэдэг бол зүгээр иргэний бүртгэлийн байгууллага хариуцдаг болгочихсон учраас сонгуулийн хороодын үүрэг роль хүртэл буурчихсан байхгүй юу бүүр. Эд нар болохоор Монгол Улсын хэмжээнд нэгдсэн сантай болоод сүүлийн үеийн цахим сангууд нь нэг болоод олон алдаа дутагдал байгаа ч гэсэн ерөнхийдөө цэгцрээд, цэгцрээд л яваад байгаа.

Одоо эд нар ингээд хийчихээр чинь АН-ын санал гэдэг чинь зөв байна шүү дээ. Бүр иргэний бүртгэл чинь өөрөө нэгдсэн сантай учраас тэндээ бүртгэлийн хуудас авч байгаа сонгогчийг чинь тусад нь тэмдэглээгээ хийгээд л, өөр газар тэр давхардахгүйгээр энэ бүртгэлийн юманд бүртгэгдсэн байна гээд ирэхээр хянагдаад тэгээд дээр нь тэр тулган таниулах ажиллагаа гэхээр чинь нөгөө манай зарим улсуудын хардаад байгааг чинь бас л ингээд л улам л хяналттай л болгож байгаа л санаа байхгүй юу. Урьд өмнөх гараад байсан юмнууд чинь ер нь бол бараг алга болчихсон юм. Тэрэн дээр гол оролцсон хүн нь Зандаахүүгийн Энхболд, энэ Нямаагийн Энхболд бид хэд энийг нь дэмжээд явчихсан.

Тэгээд сонгуулийн хороодын хамгийн хэцүү юм чинь санал тоолох, сонгогчдыг бүртгэх байсан байхгүй юу. Одоо бүртгэл нь бол иргэний бүртгэл гээд

төрийн албан хаагчид хариуцдаг болчихсон. Тэнд хааяа нэг алдаа гардаг, тэр нь ямар алдаа гардаг вэ гэхээр орох оронгүй ингээд олон дүүрэг солиод явдаг хүмүүс байна шүү дээ. Би цагтаа гэхэд 6 дүүргийн өрөө хэсээд л явж байсан хүн байхгүй юу. Тэр хүн чинь нэг хороон дээр бүртгэлтэй дандаа бас тогтвортой байхын тулд нэг ганц, хоёр хороон дээр байдаг. Тэгэхдээ өөр хороо руу оччихдог байхгүй юу. Гэтэл энэ Улаанбаатар хотод бол жишээлбэл олон 10 мянган ийм орон гэргүй шилжээд явдаг хүмүүс тэр иргэний бүртгэл дээр асуудал гардаг уу гэвэл гардаг. Яагаад гэвэл тэр чинь тогтсон орон байр байхгүй учраас амьдралаа бодоод нэг хороон дээр бүртгэгдчихдэг, тэр нь болохоор нэг айлын юман дээр давхарддаг явдал байдаг юм. Тэрэн дээр нь тоглолтууд яваад байдаг байхгүй юу. Тэр чинь ахуй амьдралын холбоотой асуудал байхгүй юу бүртгэлийн гэхээсээ гадна. Тийм юм байдаг юм шүү. Тэгээд энэ бол зүгээр орж ирж байгаа нь бол би бол илүү л одоогийнхоо хувьд хардлага сэрдлэгээ улам л хяналттай болгох гэж байна гэдэг утгаараа ярьж байна. Зүгээр нэр томьёо тэр нөгөө найруулгаа анхаарна биз. Ялгах тэмдэглэгээ биш тусгайлан тэмдэглэх л асуудал юм байна шүү дээ тийм.

Н.Энхболд: Туваан гишүүн нэг минут, Туваан гишүүн нэг минут.

Ц.Туваан: Энэ юу Сүхбаатар гишүүнээ санал нэг байна, зөв. Тэгэхдээ юу гэж асуугаад байгаа гэхээр энэ ийм байхгүй юу, одоо та ингээд ялган тэмдэглэнэ гэж байна шүү дээ. Тэгэхээр ялган тэмдэглэгээг онлайн байхгүй, сүлжээ байхгүй газарт тэр нэгдсэн санал руугаа яаж тэмдэглэгээгээ өгөөд гарах вэ гэдэг асуудлыг л би тодруулж байгаа юм. Жишээлбэл сүлжээгүй газарт харин тийм, техникийн боломжоо хэлээч. Тэрнээс биш яг энэ нэгдсэн сан ялгах энэ тэрийгээ бол тиймэрхүү нөгөө би миний яриад байгаа Батсуурь гишүүн бид хоёрын яриад байгаа юм бол хангагдаж байна гэж үзэж байгаа юм. Тэгэхээр сүлжээг хуучин чинь танайх хэсгийн

хороод руугаа өгдөг сан чинь 2000 хүний нэр ингээд өгчихдөг байхгүй юу. Нэгдсэн 2,1 сая биш. Тэр 2100 дотор чинь Туваан гэдэг нэр энэ нэг хэсгийн хороон дээр байхад дараагийн хэсгийн хороон дээр давхар байна гэдэг хар яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ арилж байна уу, энийгээ ялган тэмдэглэгээгээр онлайн хийж чадах уу гэдгийг л би асуугаад байгаа юм.

Н.Энхболд: Техникийн тийм боломж бий юу хариулъя 3.

А.Лувсан-Очир: ХХЗХ Лувсан-Очир асуултад хариулчих уу? ХХЗХ Лувсан-Очир. Сүлжээтэй холбоотой асуудал бол өчигдөр ажлын хэсэг дээр бол ярьсан. Үүрэн багт бол сүлжээ оруулахтай холбоотой бол энэ бол нийтийн хэрэглээний сүлжээ, үүрэн холбооны сүлжээ, яриа, мессеж, датаны сүлжээ оруулах асуудал байгаа юм. Харилцаа холбооны тухай хуулийн 5 дугаар зүйл дээр бол сүлжээг бол үндсэн 3 хэсэгт хуваадаг байгаа. Нийтийн хэрэглээний сүлжээ, тусгай хэрэглээний сүлжээ, дотоод хэрэглээний сүлжээ гэж байгаа. Тэгэхээр улсын бүртгэлийн энэ мэдээлэлтэй холбоотой сүлжээ маань бол өөрөө нийтийн хэрэглээний сүлжээгээр дамжигддаггүй, тусгай хэрэглээний сүлжээнд бол хамаардаг учраас тухайн цахим сүлжээ ороогүй байгаад байгаа, үүрэн холбооны сүлжээ ороогүй байгаа газарт нийтийн сүлжээ оруулсан ч энэ нь тусгай хэрэглээний сүлжээгээр, тусгай сүлжээгээр дамжигддаг өгөгдөл бол бас дамжих боломжгүй юм гэж хариулж байна.

Б.Наранцэцэг: Нэмээд, нэмээд нэг. Тийм, ер нь бол ер нь бол улсын бүртгэлийн байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэхдээ тодорхой юу гэдэг юм дэс дараалалтайгаар ингэж үйлдэж, тухай тухайн үеийн нөгөө зохицуулалтуудыг бол хуулиар хийж явдаг л даа. Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдээд одоо юу гэдэг юм сонгуулийн 2048 сонгуулийн хэсгийн хорооны компьютерт бол хуулах процесс хийгддэг. Энэ үйл

ажиллагаа маань 1 дүгээрт СЕХ, ТЕГ, Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газар, Цахим яам гэсэн холбогдох төрийн байгууллагуудаас оролцсон төлөөллүүд байж байгаад тухайн сонгогчийн программ хангамжийг баталгаажуулж гэрчилгээжүүлэх үйл ажиллагаа явагдаж байдаг. Энэ гэрчилгээжүүлэх үйл ажиллагаа явагдсаны дараа манайх сонгогчдын нэрийн жагсаалт дээр сонгуулийн санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлсэн нэрийн жагсаалт дээр тодорхой хэмжээний улсын бүртгэлийн өөрчлөлтүүд бол тусгаж байдаг. Нэрийн жагсаалт хүргүүлснээс хойш нас барсан, овог, эцэг, эх, нэрээ өөрчилсөн зэрэг янз бүрийн иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлтүүд байдаг. Энэ өөрчлөлтүүдийг бол бид нар тухай, тухай бүрд нь бол тусгаад явдаг.

Энэ тусгаж явсан өөрчлөлтүүдийгээ хамгийн сүүлийн байдлаар программаа түгжээд, программыг тагнуулын байгууллагууд бол хүлээлгэж өгдөг. Энэ цаг мөчөөс эхлээд тухайн нэгжийн компьютерт нэрийн жагсаалтыг хуулах үйл ажиллагаа маань бол тагнуулын байгууллагын хяналт доор хийгддэг ийм үйл ажиллагаа. Тэгэхээр зэрэг энэ дээр нэг хүнийг дахин, дахин хувилах ч юм уу, ингэх асуудал бол ямар ч гарах боломжгүй л гэж үзэж байгаа.

Н.Энхболд: Батсуурь гишүүн, Батсуурь гишүүнийх.

Ж.Батсуурь: Одоо, Туваан гишүүн байж байгаарай. Одоо хэдүүлээ энэ хууль ярьж байгаа дээр л улсын бүртгэл нь, СЕХ нь, ХХЗХ нь бүх зүйлээ тохироод авчих ёстой л доо. Жишээлбэл бид нар ингээд банкны гүйлгээ хийхэд Хаан банкны ч юм уу, Голомт банкны гүйлгээ хийхэд ингээд шууд тэр дороо ахиж өөр газраас гүйлгээ хийх боломжгүй тэр бүгдээрээ харагддаг шиг л болгох гээд байгаа юм. Тэгэхээр саяын улсын бүртгэлийн энэ эмэгтэйн хэлээд байгаа бол нэрсийн жагсаалтыг компьютеруудад хуулж өгнө гээд байгаа байхгүй юу. Энэ бол механик заавал нэг

давхар үйлдэл бий болоод байна шүү дээ. Бидний хүсээд байгаа зүйл бол 1 дүгээрт тэр хэн ялах аль нам нь 30 дугаар асуудал. Ерөөсөө сонгуулийг шударга явуулдаг болъё, нэг хүн 2 өгдөггүй болъё. Энэ дээр л манай Сонгуулийн хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, Улсын бүртгэлийн газар хууль батлах гэж байгаа бид нар нэг мөр ойлголттой болмоор байгаа байхгүй юу. Жишээлбэл бусад бүх зүйлүүд болоод байна шүү дээ. Жишээлбэл банкны гүйлгээ.../минут дуусав/

Н.Энхболд: Саналаа хураацгаая. 65.16 дээр ажлын хэсэг бас тэр юугаа найруулгаа ойлгомжтой болгоод биччихээрэй. Санаагаа бол ер нь бүгдээрээ ойлголцлоо тийм ээ. Энэ саналыг 25 дугаар саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 58,3 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 1 дүгээр зүйлийн 44 дэх заалтын 67¹ дугаар зүйлийн 67¹.4, 67¹.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“67¹.4.Энэ зүйлд өөрөөр заагаагүй бол гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагаанд энэ хуулийн 65, 66 дугаар зүйлд заасан журмыг баримтална.”

“67¹.6.Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн энэ хуулийн 59.4.2-т заасан хэсэгт саналаа өгнө.” Намд өгнө, намд гэсэн үг. Түрүүн хоёуланг нь уншигдсан, нэг уншсан байхгүй юу, нэг санал байхгүй юу, тийм. Тэрийг нь анзааръя. Саяын ажлын хэсгийн саналыг дэмжье санал хураалт. Санал хураалт. Сая хэлсэн ажлын хэсэг анхаарч байгаа байх. Тийм. 66,7 хувиар санал дэмжигдлээ.

27.Төслийн 1 дүгээр зүйлийн 45 дахь заалт буюу 67 дугаар зүйлийн 67.17 дахь хэсгийн “төв комисст” гэсний дараа “гадаадад санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө” гэж нэмэх.

Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

28.Төслийн 1 дүгээр зүйлийн 48 дахь заалт буюу 71 дүгээр зүйлийн 71.11 дахь хэсгийг хасах. Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт. Мөнх-Оргил гишүүнээ. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

29.Төслийн 1 дүгээр зүйлийн 49 дэх заалт буюу 72¹ дугаар зүйлийн 72¹.4 дэх хэсгийн “дипломат төлөөлөгчийн газарт” гэснийг “салбар комисст” гэж өөрчлөх. Санал хураалт. 54,5 хувиар дэмжигдэж байна.

30.Төслийн 1 дүгээр зүйлийн 50 дахь заалтын 74.1 дэх хэсэг, 74.1.3, 74.1.4 дэх заалтыг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдэж байна.

31 дүгээрх санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 51 дэх заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.2.2 дахь заалтын “3” гэснийг “4” гэж өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлийн 52 дахь заалтыг хасах. Ажлын хэсэг, санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

32.Төслийн 1 дүгээр зүйлийн 53 дахь заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсгийн 74.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“74.3.2.Энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвслийн авсан саналын хувь болон нийт нам, эвсэлд өгсөн хүчинтэй саналын хувь хоорондын зөрүүг энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвсэлд тэнцүү хэмжээгээр хуваан нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцно.” Ажлын хэсгийн санал дэмжье. 63,6 хувиар санал дэмжигдлээ. Ажлын хэсэг дээрээ бас тэрийгээ анхаараарай.

33.Төслийн 1 дүгээр зүйлийн 53 дахь заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.3.3 дахь заалтын “38-д” гэснийг “48-д” гэж, 74.3.4 дэх заалтын “38-д” гэснийг “48-д” гэж тус тус өөрчилж, төслийн 1 дүгээр

зүйлийн 54 дэх заалтыг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт 63,6 хувиар санал дэмжигдлээ.

34.Төслийн 1 дүгээр зүйлийн 53 дахь заалт буюу 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 74.3.5 дахь заалт нэмж, 74.3.4 дэх заалтын тайлбарыг хасах.

“74.3.5.энэ хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3.4-т заасны дагуу нэг суудалд ногдох саналын хувьд хуваахдаа бутархай нарийвчлалтай гаргаж, эхний ээлжид бүхэл хэсэгт нь тэнцэх суудлыг хуваарилах, хэрэв хуваарилагдаагүй суудал үлдвэл хамгийн их үлдэгдэлтэйгээс нь эхлэн нэг нэгээр суудлыг нам, эвсэлд нэмж хуваарилах зарчмаар бүх суудлыг хуваарилж дуусгана.

Тайлбар: Хуваарилагдаагүй суудал гэж энэ хуулийн 74.3.4-т заасны дагуу нам, эвслийн авсан саналын бүхэл хэсэгт нь ногдох суудал хуваарилахад суудал хуваарилагдаагүй үлдсэн, мөн нам, эвслийн авсан саналд ногдох суудлын тоо нь тухайн нам, эвслийн жагсаалтаар нэр дэвшигчийн тооноос их тооцогдсоны улмаас суудал хуваарилагдаагүй үлдэхийг ойлгоно.” Санал хураалт ажлын хэсэг. Тэгээд үлдэнэ. 63.6. 63.6 гэнээ. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

35.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг:

4.2.Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Тийм байна. 34 дэх саналыг хурааснаар хууль нэгдсэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа. Одоо сонгууль Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн 2 дахь зүйлийг хэлэлцэх асуудалдаа оръё. Энэ дээр ажлын хэсгээс гарсан саналууд байгаа.

35.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг:

4.2.Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” Энэ Үндсэн хуулийнхаа үгтэй яг нийцэж байгаа байгаа. Тэрийг анзаараарай. Санал хураалт ажлын хэсэг. 54,5 хувиар дэмжигдлээ.

36.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг хасах. Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

37.Төслийн 2 дугаар зүйлд 4 дэх заалт буюу 14 дүгээр зүйлийн 14.12 дахь хэсгийг хасах. Зүйлийн байлгүй дээ энд. Санал хураалт, зүйлд гээд, зүйлд хасах гэсэн чинь сонсогдохгүй л байна даа, хараарай энийг. Тийм, хассан юм уу заалт. 63,6 хувиар дэмжигдлээ.

38.Төслийн 2 дугаар зүйлийн 8, 9 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8/30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг:

“30.1.Нам, эвсэл нь 78 хүртэл хүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрогт, 48 хүртэл хүнийг нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ.” Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Энэ тоог чинь хэдүүлээ Үндсэн хуульдаа бүүр заагаад өгчихсөн юм чинь заавал хүртэлх хэрэг байна уу? Үгүй ээ, үгүй. Тэгээд энэ чинь 5 хүн дэвшвэл.../үг тасрав/

Н.Энхболд: Үгүй ээ тэгэхээр ийм ойлголт гардаг юм.

Ж.Батсуурь: 5 хүн дэвшүүлбэл яах юм бэ, 5 тойрогт дэвшүүлбэл яах юм бэ?

Н.Энхболд: Болно болно. Тийм.

Ж.Батсуурь: Үгүй ээ үгүй, тэгж болохгүй шүү дээ энэ чинь. Үгүй ээ юу гэсэн үг юм.

Н.Энхболд: Бүгдэд нь дэвшүүл гэж шаардаж болохгүй шүү дээ. Зөв, зөв тийм тэрийг нь зааж өгөх хэрэгтэй. Тэгэхгүй бол асуулт гардаг юм бас. Жишээ нь, зарим жишээ нь зарим газраас ингэсэн шүү дээ.

Ж.Батсуурь: Үгүй ээ харин тэгэх л ёстой байхгүй юу.

Н.Энхболд: Батсуурь гишүүнээ зарим ийм санал хүртэл гарч байсан.

Ж.Батсуурь: Босгоо давахгүй байж нам гэж явах хэрэг юу байдаг юм.

Н.Энхболд: Тэр намынх нь асуудал. Босгоо тусдаа заачихсан.

Ж.Батсуурь: Үгүй ээ, заагаад өгсөн босгоо давж чадахгүй байж тэгээд хүн дэвшүүлж байх юу байдаг юм.

Н.Энхболд: Тэр намуудынх нь өөрснөө шийдэх асуудал юм, тийм. Хэтрүүлж болохгүй л гэсэн санаа. 1 ч байж болно, 48 ч болно. Нэг хүнтэй. Тийм. Санал хураалт. Энэ санал, энэ минийх ороогүй, дараагүй явж байна шүү дээ. Би санал гаргая. Би санал өгсөн чинь юу яаж миний санал тооцогдоогүй байна. Энэ саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна, дэмжиж өгөхийг хүсье. Санал хураалт. Мөнх-Оргил гишүүнээ. Хуулиа л явуулах гээд байх шиг байна. Энэ чинь дэмжигдэхгүй байна даа. Тэгвэл ингэлээ шүү Батсуурь гишүүнээ. Ингэж ойлгогдоод та санал гаргалаа, тэр санал нь юу гэсэн үг вэ гэхээр нам заавал 48 хүнийг дэвшүүлнэ, заавал 78-ыг дэвшүүлнэ гэсэн санал АН-ын гишүүн гаргалаа гэж ойлгогдоод энэ

санал дэмжигдсэнгүй шүү. Болохгүй л дээ тийм, болохгүй дэмжихгүй байгаа юм чинь яах юм тийм. Яах юм бэ ажиллая. 2 дугаар хэлэлцүүлэг дээр энэ энийгээ ярь. Би сая хэлчихлээ шүү дээ. Энэ дээр харин намаа хэлээд АН-ын гишүүн Батсуурийн гаргасан саналын дагуу намууд заавал тойрогт 78, заавал 48-ыг жагсаалтаар гэж. Хүрэхгүй бол сонгуульд оруулахгүй гэсэн санал гаргаад тэр нь дэмжигдлээ гэж ойлгоё. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгчих, микрофондоо өгчих.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр заавал дэмжих хэрэгтэй. Тэгэхээр энэ заалтыг заавал дэмжих хэрэгтэй байгаа юм. Энэ заалтыг дэмжихгүй болохоор үлдэж байгаа заалт нь ямар заалт вэ гэхээр Үндсэн хууль зөрчсөн заалт үлдэж байгаа юм. Тэр нь нам эвсэл нь 38-аас илүүгүй хүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрогт, 38-аас илүүгүй хүнийг жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ гээд нөгөө Үндсэн хуульд байхгүй 2 тоо болчихож байгаа юм. Тийм учраас энийг заавал дэмжээд 78, 48 гээд тоогоороо явахгүй бол бид нар Үндсэн хууль зөрчсөн тоог юунд оруулж болохгүй шүү дээ чуулганд. Тийм учраас би энийг ингээд Батсуурь гишүүнийг дэмжээд явчих, Их Хурлын таны үг хэлэх чинь бол болж байна. Энэ дээр бол эсрэг санал өгч хэрэггүй, энэ тийм Үндсэн хууль зөрчсөн асуудал юм чинь гэж би тэгж хэлэх гэж байгаа юм.

Н.Энхболд: Тийм нэгд Үндсэн хууль зөрчсөн, хоёрт намуудыг заавал та нар жагсаалтаар заавал 48-ыг дэвшүүл, бүх тойрогт заавал нэр дэвшүүл гэж шахаж байгаа юм шиг ийм юм бас санаа цаана орчхоод байгаа байхгүй юу. Тийм учраас тэгээд горимын санал гаргах уу? Саналыг хүчингүй болгож өгөөч гээд тэгээд дахиж санал хураана шүү дээ. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөөч. Яагаад вэ гэхээр би гол нь нэгд нь энэ нөгөө Үндсэн хууль зөрчигдөж байгаа

заалт учраас хүчингүй болгох горимын санал гаргаж байгаа юм.

Н.Энхболд: Тогтохсүрэн гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 70 хувиар, 70 хувиар санал дэмжигдлээ. Одоо дахиад түрүүчийнхээ томъёоллоор нам эвсэл 78 хүртэл хүнийг сонгуулийн тойрогт 48 хүртэл хүнийг жагсаалтаар гэсэн агуулгатай саналаа дэмжье гэсэн ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулъя. 70 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Төслийн 2 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1 дүгээр зүйлд нэмж, дугаарлалтуудыг өөрчлөх:

“30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг:

30.3.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье. 70 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг:

42.1.Тойрог тус бүрд нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан дараах шаардлагыг хангасан нэгдсэн самбартай, зурагт хуудсыг байрлуулсан дараах энэ найруулга яагаад. Тойрог тус бүрд нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан дараах шаардлагыг хангасан нэгдсэн самбартай байна. Сум, дүүргийн засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан журмын дагуу нэгдсэн самбарыг бэлтгэж, байрлуулах ажлыг зохион байгуулна.

42.1.1.энэ хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн зурагт хуудсыг байрлуулах дарааллыг тогтооно;

42.1.2.сонгуулийн сурталчилгааны нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй ашиглуулна;

42.1.3.нэгдсэн самбарт байрлуулах нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны дөрөвний нэг хэмжээтэй байна;

42.1.4.сонгогчийн тоонд үндэслэн суманд хоёр хүртэл, хороонд гурав хүртэл нэгдсэн самбар байрлуулна.” Ажлын хэсгийн санал байна. Дэмжье санал хураалт. Чи дараа нь наадхаа өөрөө тайлбарлаж хэлээрэй, би чамд микрофон өгчихнө. Ярьж байгаад саналаа хоцорчихлоо доо. Би минийх сая Тогтохсүрэн намайг уруу татаж байгаад буруу санал өгүүлчихлээ. Тийм би горимын санал гарч байна. Саяын санал хураалтыг хүчингүй болгохыг дэмжиж өгөхийг хүсье. Санал хураалт Адьяасүрэн гишүүн бас анхааралтай байгаарай. 72,7 хувиар дэмжигдлээ. Тийм учраас түрүүчийн уншсан томъёоллоор үндсэн саналаа дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт. Санал хураалт 72,7 хувиар санал дэмжигдлээ.

41.Төслийн 2 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу 48.9 дэх хэсгийн “орохыг” гэснийг “орох, нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигч ухуулах байр ажиллуулахыг” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн санал, саналыг дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

42.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“50.2.Сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох аргачлал нь сонгуулийн зардлыг бууруулахад чиглэх бөгөөд сонгуулийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, энэ хуульд заасан бусад шаардлагад үндэслэнэ. Аргачлалыг төрийн аудитын дээд байгууллагын саналаар Сонгуулийн ерөнхий хороо батална.” Саналыг дэмжье. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

43.Төслийн 2 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийг хасах. Санал хураалт. Ажлын хэсгийн саналыг дэмжье. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

44.Төслийн 2 дугаар зүйлийн 14 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14/65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг:

65.6.Санал авах байранд ажиллаж байгаа итгэмжлэгдсэн ажилтан сонгогчийн гарын хурууны хээг сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбартай тулгаж, энэ хуулийн 66.5-д заасан бэхэн тэмдэглэгээ хийгдсэн эсэхийг нягтлан, зөрчилгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.” Ажлын хэсгийн саналыг дэмжье. Энэ нөгөө бэх юмнууд нь байгаа юу? Ер нь Бат-Эрдэнээ бэх нь байгаа юу?

Д.Тогтохсүрэн: Байгаа.

Н.Энхболд: 45. 72,7 хувиар саяын санал дэмжигдлээ. 45.Төслийн 2 дугаар зүйлийн 15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“66.2.Сонгогч энэ хуулийн 59.4.2-т заасан хэсэгт нам, эвсэлд саналаа өгнө.” Нэг нам эвсэлд саналаа өгнө. Санал хураалт ажлын хэсгийн санал. Ажлын хэсгийн дарга санал хураалтыг битгий үймүүлээд байгаарай. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

46.Төслийн 2 дугаар зүйлийн 16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“66.5.Сонгогч саналаа тэмдэглэсэн саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийсний дараа тухайн сонгогч саналаа өгснийг илэрхийлэх бэхэн тэмдэглэгээг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу хийнэ.” Санал хураалт, ажлын хэсгийн саналыг дэмжье. 63,6

хувиар энэ санал дэмжигдлээ. Ингэснээр хуулийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн санал 3 дугаар зүйлийг хэлэлцэж эхэлье. 47 дугаар санал. 47.Төслийн 3 дугаар зүйлийн “5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “иргэн” гэсний дараа “гадаад улсад суугаа Монгол Улсын иргэн” гэж,” гэснийг, “20.1 дэх хэсгийн “шийдвэрлэх ажлыг” гэсний дараа “Сонгуулийн ерөнхий хорооны хяналт дор” гэж, “зохион байгуулж,” гэсний дараа “энэ хуульд заасан журмын хүрээнд” гэж, 20.5 дахь хэсгийн “холбогдох мэдээлэлтэй” гэсний дараа “болон байнга оршин суугаа хаягт бүртгэлтэй бусад сонгогчдын мэдээлэлтэй” гэж, 20.13 дахь хэсгийн “цахим хэлбэрээр” гэсний өмнө “санал авах өдрөөс 5 хоногийн өмнө 2 удаа” гэж,” гэснийг, 20.15 дахь хэсгийн “жагсаалтыг” гэсний дараа “хуульд зааснаас бусад тохиолдолд” гэж,” гэснийг, ““жагсаалт дахь” гэсний дараа “энэ хуулийн 20.5 дахь хэсэгт заасан” гэж, “буруу бүртгэгдсэн,” гэсний дараа “байнга оршин суугаа газрын хаягт нь бүртгэлгүй сонгогч нэмэгдсэн зэрэг асуудлаар” гэж,” гэснийг, “, мөн хэсгийн “нэвтрүүлнэ.” гэсний дараа “Сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний хуваарь, цагийг тэнцүү хэмжээнд тогтооно.” гэж,” гэснийг, “67 дугаар зүйлийн 67.14 дэх хэсэгт “67.13” гэсний өмнө “67.1” гэж,” гэснийг тус тус хасах. Санал хураалт ажлын хэсэг. Батсуурь гишүүнээ саналаа өгөөрэй. 63,6 хувиар санал дэмжигдэж байна.

48.Төслийн 3 дугаар зүйлийн “харилцах” гэсний өмнө “хороотой” гэж, “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “Нэр дэвшигч нь” гэсний өмнө “Сонгуулийн тойрогт” гэж, “54 дүгээр зүйлийн” гэсний өмнө “51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “эвсэл болон” гэсний дараа “сонгуулийн тойрогт” гэж,” гэж, “54 дүгээр зүйлийн 54.2 дахь” гэсний дараа “хэсгийн “эсхүл” гэсний дараа “сонгуулийн тойрогт” гэж,” гэж тус

тус нэмэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

49.Төслийн 3 дугаар зүйлийн “14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “хороо” гэсний дараа” гэснийг “мөн зүйлийн 10 дэх хэсгийн “захиргааны байгууллага” гэсний дараа “, сум, дүүрэг” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “болон хэсгийн хороо” гэсний дараа” гэж, “50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийн” гэснийг “50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсгийн” гэж, “тоо нь саналаа өгсөн нийт сонгогчийн” гэснийг “тоо нь тухайн хэсгийн хорооны хүлээн авсан саналын хуудасны” гэж, “, нам, эвсэл тэдгээрээс жагсаалтаар нэр дэвшигчийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам, эвсэл болон жагсаалтаар нэр дэвшигчид нэгээс илүү санал тэмдэглэсэн” гэснийг “, нам, эвслийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам, эвсэлд санал тэмдэглэсэн” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 83,3 хувиар санал дэмжигдсэн. Үүгээр төсөл нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

4 дүгээр зүйлийг хэлэлцэж эхэлье. 50. Төслийн 4 дүгээр зүйлийн “11 дүгээр зүйлийн” гэсний өмнө “10.1.14 дэх заалтын “46, 47, 48.9-д” гэснийг “46, 47 дугаар зүйл, 48.9, 48.10-д” гэж,” гэж, “13 дугаар зүйлийн” гэсний дараа “13.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэр, төвийг” гэснийг “нутаг дэвсгэрийг” гэж, мөн зүйлийн” гэж, “21 дүгээр зүйлийн” гэсний өмнө “20.15 дахь хэсгийн “хувилж олишруулах,” гэснийг “энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хэвлэж” гэж,” гэж, “21.1 дэх хэсгийн” гэсний дараа ““нутаг дэвсгэр, төвийг” гэснийг “нутаг дэвсгэрийг” гэж,” гэж, “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө “38 дугаар зүйлийн 38.7, 38.8, 38.12 дахь хэсгийн “26.3.6, 26.4.6” гэснийг “38.13” гэж,” гэж, “46.4 дэх хэсгийн” гэсний өмнө “зүйлийн 46.2 дахь хэсгийн “тогтоосон” гэснийг “баталсан” гэж,” “Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран” гэсний өмнө “журмыг” гэж, “Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг

үндэслэн” гэсний өмнө “, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмыг” гэж, “60 дугаар зүйлийн” гэсний өмнө “58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсгийн “26.3.6, 26.4.6, 38.5” гэснийг “38.5, 38.13” гэж,” гэж тус тус нэмэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. 84,6 хувиар санал дэмжигдлээ.

51.Төслийн 4 дүгээр зүйлийн “санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө” гэснийг “цахим хэлбэрээр нэг удаа” гэж, “нам, эвсэл бүртгүүлснээс хойш ажлын 3 хоногт” гэснийг “болон санал авах өдрөөс 3 хоногийн өмнө тус тус цахим хэлбэрээр” гэж, “32.11 дэх хэсгийн “тав” гэснийг “долоо”” гэснийг “32.11 дэх хэсгийн “хүлээн авснаас хойш тав” гэснийг “хүлээн авах хугацаа дууссанаас хойш долоо”” гэж, “хугацаа” гэснийг “хуваарь, цагийг” гэж, “тэдгээрээс тойрогт болон жагсаалтаар нэр дэвшигч, бие даан” гэснийг “тэдгээрээс тойрогт нэр дэвшигч, бие даан” гэж, тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт гишүүдээ, Сүхбаатар, Ганбатаа санал хураалт. Энийг яахаараа дуусгачихъя. Энэ 4 дүгээр зүйл байна шүү дээ. Дуусаагүй ээ. Дараа нь уншчихъя. 52 дугаар, 51 дүгээр санал 76,9 хувиар дэмжигдлээ.

52.Төслийн 4 дүгээр зүйлийн “20 дугаар зүйлийн 20.11, 23.1, 24.1, 24.2, 24.3 дахь хэсгийн “14-өөс” гэснийг “16-аас” гэж, 20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсгийн “14-өөс доошгүй” гэснийг “5-аас доошгүй” гэж,” гэснийг, “42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн “аймгийн төв болон дүүргийн нэг хэсэгт 5, бусад хэсэгт 3-аас” гэж,” гэснийг, “50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийн “харгалзан Сонгуулийн ерөнхий хороо болон Монгол Улсын Ерөнхий аудитор хамтран батална.” гэснийг “үндэслэл болгоно.” гэж,” гэснийг, 5 дугаар зүйлийн “13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “, төвийг” гэснийг,” гэснийг, “29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийн “ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө, ээлжит бус,

нөхөн сонгуулийн тухайд” гэснийг,” гэснийг, “54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “нам, эвсэлд, эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш” гэснийг,” гэснийг, 6 дугаар зүйлийн “4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2, 12 дугаар зүйлийн 12.4, 14.12 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.15 дахь хэсэг” гэснийг, “50 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг,” гэснийг, “, 65 дугаар зүйлийн 65.6 дахь заалтыг” гэснийг, “26.3.5,” гэснийг тус тус хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. Санал 69,2 хувиар санал дэмжигдлээ. Энэ 4 дүгээр зүйлтэй холбоотой юм уу? Ажлын хэсгээс гарсан 4 дүгээр зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж дууслаа.

Одоо гишүүдээс мөн зүйлтэй холбоотой ирсэн саналын томъёоллоор санал хураалгана. Сарангэрэл, Одонтуяа, Оюунчимэг, Адъяасүрэн, Доржханд, Сүхбаатар нарын. Би саналын томъёоллыг нь уншаадахъя. Тийм. Саяын гишүүд Сарангэрэл, Одонтуяа, Оюунчимэг, Одонтуяа, Адъяасүрэн, Доржханд, Сүхбаатар нарын гишүүдээс нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн 30 дугаар зүйлийн 30.20 дахь хэсгийн 20-иос гэснийг 30-аас гэж гэснийг 20-иос гэснийг 40-өөс гэж өөрчилье гэсэн зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн байна. Батсуурь гишүүн үг хэлье гэсэн. Батсуурь үгээ хэлэх үү? Батсуурь гишүүний микрофоныг өгөөрэй.

Ж.Батсуурь: Би ажлын хэсгийнхэнд Энхболд даргаа би энэ ажлын хэсгийнхэнд нэг зүйлийг бас анхааруулж хэлье. Та хэд нягталж үзээч гэж хэлэх гэсэн юм. Жишээлбэл нэгдсэн сан, нэгдсэн сан бол би үгээрээ нэгдсэн сан байгаа боловч бодит Пүрэвдоржоо байж бай л даа. Аягүй чухал байна. Нэгдсэн сан гэвэл би энэ үгээрээ нэгдсэн сан гэж орж байгаа боловч нэгдсэн сан биш байна гэж би ойлгох гээд л. Түрүүнд би тайлбарлах гээд барсангүй л дээ. Жишээлбэл таны юм уу миний Хаан банкны дансанд сая төгрөг байлаа. Энэний би 500000-ыг нь авчихаар

500000-ын үлдэгдэл байна. Өөр хаанаас ч 500 мянга авч болохгүй биз дээ? Тэгэхээр энэ нэгдсэн санг олон компьютерт хуулаад өгчихнө гэдэг чинь компьютер болгоноос тэр үлдэгдлийг авах боломж бүрдэж байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь энэ чинь нэгдсэн сан биш. Нэгдсэн сан гэдэг бол нэгдсэн санд байгаа 2 сая 100 мянган сонгогчоос тийм ээ тухайн хэсэгт хасагдсан нь offline болоод явахыг л нэгдсэн сан гэнэ үү гэхээсээр тэр санг бүгдийг өөр, өөр компьютерт хуулаад өгчихнө гэдэг чинь бол нэгдсэн сан биш. Тэгэхээр энийг бас техникийн хувьд анхаарч өгөөч гэж.

Н.Энхболд: Тийм түрүүн Сүхбаатар гишүүн нэлээн тодорхой тайлбарласан. Энэ бүртгэл замбараатай болж байгаа, янз бүрийн маргаанууд байхгүй болсон. Эх үүсвэрүүд яаж тавигдсан талаар. Тэгэхээр тэрийг бас анхаараарай, бүртгэлийн байгууллагынхан манай ажлын хэсэгтэй яриад яг ямар утгаар тэрийгээ бичсэн юм хэлээд хэрэв ойлгогдохооргүй байгаа бол нэгдсэн сангаас тухайн сонгуулийн хэсэг дээр тастаад авчихсан хэсгүүдийг яриад байна шүү дээ тийм ээ. Энийгээ яаж томъёолох юм тэрийгээ дахиад та нар ажлын хэсэг дээр нэг ярьчхаарай. Дараагийн хэлэлцүүлгийн өмнө. Сүхбаатар гишүүн, ажлын хэсгээс энэ чинь.

Ж.Сүхбаатар: Ийм байгаа шүү, Энхболд даргаа. Манай нөгөө өмнө нь Их Хурлын ТББХ-ны дарга байсан Мөнхбат маань энэ Жендерийн лобби бүлгийг байгуулаад ингээд ахлагчаар ажиллаж байсан юм байна лээ. Ингээд Мөнхбат маань чөлөөлөгдчихсөн. Ингээд манай жендерийн чиглэлээр ажиллаж байгаа энэ нөхдүүд маань надад их итгэл хүлээлгээд, тэгээд би бол боломж муутай гэдгээ хэлсэн ч гэсэн өмнө нь 12 жил, 12 жилийн ажлын ачаалал өндөр байна гэж хэлсэн. 12 жилийн өмнө эмэгтэйчүүдийн квотыг бол би 20 хувь квот болгох дээр нь бол ажилласан, UNDF эд нартай ажиллаж байгаад, тухайн үед бол элдэв хоёроор хэлүүлж л байсан л даа. Юун

сүрхий эмэгтэй хүн дэмждэг болчхов чи энэ тэр гээд л.

Тэгэхдээ одоо бол хандлага их өөр болчихсон байна лээ. Манай намын ЕНБД бол жишээлбэл намын лист дээр бол 1, 1 харьцаагаар ингээд бид бичнэ ч гэдэг юм уу ингээд л мэдэгдэж байна. Манай эрх барьж байгаа энэ социал нам маань бол социал демократ үзэл баримтлалтай нам. Намын дүрэмдээ ч гэсэн эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж байгаа. Бид нарын тавьж байгаа зорилт бол олон улсын өмнө хүлээсэн үүрэг л дээ. Энэ НҮБ-ын баримталж байгаа зарчим чинь 40-өөс доошгүй зарим нь бол 50 хувьд хүрээд байна шүү дээ. Тэгэхээр манайх нүү наа гээд л ярьдаг юм. Тэгэхдээ үндсэндээ өнөөдөр 126 гишүүн байлаа гэхэд сая 52 гэхэв үү тийм ээ, 52-оос доошгүй нь эмэгтэй байна гэхэд ер нь бол энэ бол нэг эрхийн асуудал гэхээсээ хөгжлийн асуудал гээд буюу хөгжлийн стратегитай холбоотой асуудал болчихоод байгаа юм.

Тэрнээс биш өнөөдрийн байгаа хэн нэгэн эмэгтэй хүнийг нэрлээд л тэр болно, болохгүй, тэр чадна, чадахгүй гэдэг энэ яриа бол хоцрогдсон хуучирсан үзэл байна гээд ингээд үзэж байгаа юм. Тийм учраас манай жендерийн лобби бүлэг гэж байгуулагдаад эмэгтэй гишүүд ороод зарим эрэгтэй гишүүд ороод нам харгалзахгүй ороод ингээд байгуулагдаж байгаа. Энд Занданшатар даргад ингээд удахгүй өнөөдөр ингээд гардуулчихна. Ингээд явж байгаа юм. Тэгэхээр бид бол хөгжлийн стратеги талаасаа Монгол Улсын хүлээж байгаа үүрэг. Өнөөдрийн тухай бид бол наана, цаана ярихаас илүүтэй ирээдүйгээ хараад ингээд бид нар 40 хувиа оруулъя, тэгээд мэдээж Улсын Их Хурлын гишүүд дор дороо бодно биз. Ер нь бол сая 1 хэсэг бүх л хүн бол эмэгтэйчүүдээ дэмжинэ гээд л сүрхий үүрэг аваад л, хэвлэл мэдээллээр яриад л өөрсдөө дэмжигч болоод л хувирсан шүү дээ.

Тэгэхээр манай бүлгийн дарга ч гэсэн энд сууж байна. Тэгэхээр өөрөө ч

гэсэн энэ дээр байр сууриа хэлэх л байх л даа. Тэгээд ямар ч байсан энд байгаа гишүүд бол ингээд итгэл үнэмшилээрээ эмэгтэйчүүдийн ч асуудал биш, 20 жилийн дараа эрэгтэйчүүдийн асуудал болж хувирах магадлалтай буцаад эргээд. Тэгэхээр энэ бол хөгжлийн асуудал учраас бид энийг оруулж байгаа шүү. Жендерийн лобби бүлэг гэж бас байгуулагдаж байгаа шүү гэдгийг бас хэлчихье. Тэгээд танхимд бас нэгдсэн хуралдаан дээр бас энийг хэлнэ.

Н.Энхболд: Санал хураалгалаа шүү. Сая би томьёолсон. Нэгтгэсэн төслийн 40 дүгээр зүйлийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн 20-иос гэснийг 30-аас гэж, гэснийг 20-иос гэснийг 40-өөс гэж өөрчлөх. Сарангэрэл, Одонтуяа, Оюунчимэг, Адъяасүрэн, Доржханд, Сүхбаатар нарын гишүүдийн гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Энэ чинь миний уг нь миний гаргасан саналыг та нар өөрчлөх гээд байгаа юм шүү дээ. Миний өөрийнхөө эсрэг санал өгүүлэх гээд байгаа. Дэмжигдсэнгүй. Горимын санал гаргах хүн байна уу? Алга. Энэ санал дэмжигдсэнгүй, чуулган дээр саналаа бас оруулж болно. 5 дугаар хэсэг тийм. Ингэснээр нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

5 дугаар зүйл хэлэлцэж эхэлье. Төслийн 5 дугаар зүйлийн “13 дугаар зүйлийн” гэсний өмнө “10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “улсын төсвөөс санхүүжих” гэснийг,” гэж нэмэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Дэмжинэ, дэмжинэ. Миний минийх болсонгүй яах вэ. 76,9 хувиар санал дэмжигдлээ. Ингэснээр 5 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 6 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна, хэлэлцэж дууслаа.

Төслийн 7 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. 7 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Найруулгын саналууд байгаа. Хураана, одоо хураалаа. Юу юм наадах чинь. Хэддүгээр зүйл дээр юм бэ? Наадах чинь юу юм бэ, юуны тухай юм бэ? Гишүүд ээ төслийн 4 дүгээр зүйлтэй холбоотой санал ирсэн байна. Энэ саналын Доржханд гишүүний санал уу? Одонтуяа. Энэ 32.18 гэснийг хасаад, хуучин 22-оор нь үлдээе буюу сонгуулийн сурталчилгааны хугацаа 18 гэж санал орсныг 22 болгоё гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал ирсэн байна. Үүнийг хураагаад хэрэв дэмжигдвэл томьёолно, дэмжигдэхгүй бол тэгээд орхигдох нь байна шүү. Санал хураалт. Унасан ч гэсэн үү? Тийм. Хуучнаараа байгаа, байгаа. 2 гишүүн дэмжиж 16 хувьтай гарч санал дэмжигдсэнгүй.

Хууль, энэ зүйл нь хэд юм бэ? 60.1 хэддүгээр зүйл дээр байна вэ? Энийгээ явуулчихъя, дараа нь энийг, тийм. Доржханд гишүүнээс ХҮН намын дарга, Их Хурлын гишүүн Доржхандаас санал ирсэн байна. Саналын хуудсанд нам эвслийн нэрийг Улсын Их Хурлын өмнөх сонгуульд авсан суудал саналын тооны ихээс бага руу жагсаан дарааллын дагуу бичнэ. Өөрөөр хэлбэл одоо бол Дээд шүүхэд бүртгэгдсэнйхээ дагуу жагсаалтад намууд бичигдэж байгаа. Доржханд гишүүний саналаар бол тухайлбал энэ Их Хуралд суудалтай намууд гэхэд жишээ нь Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам гээд тэгээд дараа нь сонгуульд авсан СЕХ-ноос гарсан дүнгээр сонгуульд санал авсан дарааллаар нь жагсаана гэсэн ийм агуулгатай заалт нэмье гэж санал гаргаж. Томьёоллоо тайлбарлаад Доржханд гишүүнд үг өгье.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр эрхэм ТББХ-ны гишүүдээ, энэ их чухал юм. Та бүгд бас анзаарсан байх. Энэ бид нар энэ том Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гээд энэ тогтолцооны өөрчлөлтийг ярьж байгаа. Энийгээ харин биежүүлээд хэрэгжүүлье гээд тэгэхээр бас сөрөг тал гарч ирж байна. Тухайлбал намын жагсаалтыг худалдах гэж байна гэдэг ийм мэдээллүүд бол сошиалд нэлээн их

явж байна. Дээр нь нэлээд их хэмжээний тэрбум, тэрбум төгрөгөөр тухайлбал Улсын дээд шүүхийн бүртгэлтэй байгаа 3-д жагсдаг намыг худалдан авалт хийгдлээ гэдэг мэдээлэл байна. Цаашаа бас 4 дэх, 5 дахь гээд ингээд мэдээллүүд явах нь. Тэгэхээр энэ бол өөрөө зарчим нь бол буруу юм. Олон улсад бол энэ чинь үр дүнгээрээ жагсдаг, манай бүүр авторитар дэглэмтэй гээд байдаг хойд хөрш хүртэл сугалаагаар ингэж явдаг. Тэгэхээр ингээд сонгуульд байнга тогтмол ордоггүй, сахилга бат байхгүй. Тэгсэн мөртөө ингээд жагсаалтад Дээд шүүхэд бүртгэхдээ бол эхний хэдэд бүртгэгдсэн гэдэг агуулгаараа үнэлж зарж байгаа энэ байдлыг бид нар зогсоох ёстой юм. Тэгээд цаашаагаар бас энэ Үндсэн хуулиа биежүүлээд явъя гэх юм бол шударга байя. Үр дүнгээр нь үндэслээд хэн хамгийн их суудал авсан юм, хэн хамгийн их санал авсан юм тэрүүгээрээ эрэмбэлэгдээд явдаг энэ зохицуулалт руу одоо бол орчихъё гэдэг ийм санал байгаа юм шүү.

Тэгээд ийм болохоор та бүгд маань энийг бас хүлээж аваад дэмжиж өгөөч. Энэ бол зөвхөн ганц нэг намын эрх ашиг биш юм. Цаашаа энэ Үндсэн хууль биежээд явахад, цаашаа бас энэ парламентын ардчиллыг бэхжүүлэхэд шударга өрсөлдөөн бий болгоход энэ маш чухал юм шүү. Ийм болохоороо энэ саналыг маань дэмжээд өгөөрэй гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Н.Энхболд: Саналыг сонслоо. Доржханд гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Хурааж байна. 4 гишүүн дэмжлээ, санал дэмжигдсэнгүй. 33,3 хувьтай гарлаа. Энэ Доржханд гишүүнээ сонгуулийн тойрог, сонгуулийн тойрог байгуулахтай холбоотой асуудлыг энэ Сонгуулийн хуульд орох хэрэг байна уу, үгүй юу? Тэр чинь Улсын Их Хурлын тогтоол гарч байж тойргоо байгуулдаг шүү дээ. Тэр үед л яах вэ энэ санал нь бол ийм байна л даа. 12.2 дахь хэсэг гэж байгаа. 12.2 дахь заалт, хаана байна вэ? Санал хураачихсан уу бид нар энийгээ

санал хураасан уу сая, хураагаагүй хэвээрээ үлдэж байгаа юу? Энэ дээр санал хураачихсан уу? Энэ заалтаар хураагдсан тийм ээ.

Доржханд гишүүнээ түрүүн таны энэ нөгөө сонгуулийн тойрог байгуулахтай холбоотой заалт бол бид нар нэгтгэсэн төслийн 12.2 дээр байж байгаа Улсын Их Хурлын 12.1 дээр нь бол ээлжит сонгуулийн жилийн 2 сарын 1-ний өдрөөс өмнө сонгуулийн тойргийг байгуулна. Ээлжит бус сонгууль явбал сонгууль авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө хуульд нийцүүлэн сонгуулийн тойргийг байгуулна. Ингэж байгуулахдаа засаг захиргааны нэгж бүрээс төлөөлөл сонгогдох, тойрогт ноогдох мандатын тоог тогтоохдоо аймаг, дүүргийн хүн амын тоо, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн байршил зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан хуулиар тогтооно гээд заачихсан байгаа. Тэгэхээр энүүгээр бид нар санал хураачихсан, одоо таны энүүгээр хураалгах шаардлагагүй гэж үзнэ. Энийг энэ асуудлаа та хэрэв заавал хөндөж тавих ёстой гэж үзвэл сонгуулийн тойрог байгуулах үед асуудлаараа саналаа боловсруулаад саналын томьёолол оруулаад хурааж болно.

Таны 3 дахь юу байна санал байна. Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал нөхөн ээлжит бус сонгуулийн тухайд хууль товлон зарласан шийдвэр, сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал гэснийг хасъя. Энэ 48.1 гэж ямар заалт байгаа юм бэ? Үгүй ээ энэ тэгээд юу байж байгаа юм бэ энэ 48.1 гээд хөндөгдчихсөн юм заачихсан байна шүү дээ энэ дээр чинь. 1 дүгээр зүйлийн 34 дэх заалт гэж. 48.1, 34 дэх заалт. Байнгын хорооны ажлын хэсгээс тайлбар өгч байна. Төсөлд тусгагдаагүй зүйл, заалтаар өөрчлөлт оруулах санал хураах боломжгүй юм байна дэгийнхээ дагуу. Яах вэ, яах вэ. Гишүүдээ, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн нэгтгэсэн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Найруулгын саналууд байгаа. Чихтэй би сонсож байна наадхыг чинь. Зүйл зүйлээр нь. Одоо найруулгын саналууд байгаа. Энэ бүх зүйлүүд орсон байгаа. Тийм.

55 дугаар санал байна. Төслийн 1 дүгээр зүйлийн 43 дахь заалт буюу 67¹ дугаар зүйлийн дугаарыг 66¹ болгож, 3 дугаар зүйлийн “10.4 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “, улсын хил хамгаалах байгууллага, батлан хамгаалах байгууллага, архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж,” гэснийг “10.4 дэх хэсгийн “дээд байгууллага” гэсний дараа “, батлан хамгаалах болон архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын хил хамгаалах” гэж,” гэж, “дагалдах хэрэглэл” гэснийг “дагалдах хэрэгсэл,” гэж, 5 дугаар зүйлийн “, 20.6.8” гэснийг “, 20.6.7, 20.6.8” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн “холбоотой өөрчлөлтийн” гэсний дараа “талаар” гэж, 7 дугаар зүйлийн “48 дугаар зүйлийн” гэсний өмнө “29 дүгээр зүйлийн 29.7, 29.8 дахь хэсгийн дугаарыг “29.8, 29.9” гэж,” гэж, мөн зүйлийн “48 дугаар зүйлийн” гэсний өмнө “30 дугаар зүйлийн 30.3, 30.4 дэх хэсгийн дугаарыг “30.4, 30.5” гэж,” гэж нэмж, 7 дугаар зүйлийн “12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн дугаарыг 12.4 гэж” гэснийг, “71 дүгээр зүйлийн “71.11, 71.12, 71.13, 71.14, 71.15, 71.16, 71.17, 71.18” дахь хэсгийн дугаарыг ““71.12, 71.13, 71.14, 71.15, 71.16, 71.17, 71.18, 71.19” гэж,” гэснийг хасах. Ажлын хэсгийн санал байна, дэмжье санал хураалт явуулъя. Тэрэн дээр нь үлдчихье шүү. Ингээд 81,8 хувийн саналаар дэмжлээ. Ингээд зүйл зүйлээр хэлэлцээд зүйлүүдтэй холбоотой найруулгын саналуудаа хэлэлцээд дууслаа.

Одоо нэг ийм санал байна. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл,

хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 90,9 хувиар санал дэмжигдлээ.

Холбогдох, дагалдаж орж ирсэн бусад хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн талаар санал хураалт явуулна.

Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Ажлын хэсгээс ирүүлсэн саналыг танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийн “хяналтын дэд хорооны” гэсний дараа “, Сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны” гэж нэмсүгэй.” Ажлын хэсгийн гаргасан санал, санал хураалтыг саналаа өгөөрэй гишүүдээ. 90,9 хувийг хувиар санал дэмжигдлээ. Өөр юм байхгүй билүү? Тэрийгээ хэлж байна. Сая бид нар ингээд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Дараагийн хууль Монгол Улсын эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байна. Ажлын хэсгээс энэ хуулийн төслийг буцаая гэсэн зарчмын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Эрүүгийн хуульд оруулах өөрчлөлт. 90,9 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн хууль Монгол Улсын төсвийн тухай нэмэлт, өөрчлөлт оруулах нэмэлт оруулах тухай хуулийн төсөл байгаа. Дагалдаж ирсэн. Ажлын хэсгээс хууль санаачлагчид нь буцаах зарчмын зөрүүтэй санал ирүүлснийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Энэ юу гэсэн үг юм бэ? Үгүй ээ, үгүй харин, байгаа юм уу,

хаана байгаа юм тэр нь? За, 90,9 хувиар санал дэмжигдлээ.

Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа. Ажлын хэсгээс гарсан саналын томъёоллыг танилцуулъя. Төслийн 1 дэх заалтын “чиглэлээр” гэсний дараа “Сонгуулийн автоматжуулсан системийн тухай” гэж нэмж, мөн заалтын “12 дугаар сарын 31-ний” гэснийг “10 дугаар сарын 1-ний” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. 81,8 хувиар санал дэмжигдлээ. Үүгээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хороо явуулж дууслаа. Санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өг дөө.

Д.Тогтохсүрэн: Сая анхны хэлэлцүүлэг хийж дууссантай холбоотойгоор Байнгын хороо хууль зүйн дүгнэлт гаргуулах 4 асуудал байгаа. Бид дараагийн хэлэлцүүлгээ нөгөө хурдавчлах, хуулийн хугацаатай учраас хууль зүйн дүгнэлт гаргуулахаар ХЗБХ-нд ийм санал хүргүүлэх ёстой юм. Тийм учраас би 4 асуудлаар хууль зүйн, хууль зүйн дүгнэлт гаргуулахаар 4 асуудлаар юу билүү Их хурлын Тамгын газарт билүү хууль зүйн дүгнэлт гаргуулах чинь тийм. Их Хурлын тамгын газарт хууль зүйн дүгнэлт гаргуулах 4 асуудал байгаа юм. Тэгээд энийг Байнгын хорооны хурлаараа хэлэлцэж дэмжээд, тэгээд дараагийн хэлэлцүүлэг дээрээ дүгнэлтийг нь сонсож ярилцах юм.

1 дүгээрт нь нэгдсэн зурагт самбарын зохицуулалттай холбоотойгоор 42 дугаар зүйлийн 42.2, 42.6, 42.7 дахь хэсгийг хасах, нам эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын сурталчилгааны самбартай холбоотой зохицуулалтыг нэмэхтэй холбоотой

асуудал байгаа юм. 2 дугаарт нь бэхэн тэмдэглэгээ хийх зохицуулалт дэмжигдсэнтэй холбоотойгоор 64 дүгээр зүйлийн 66.14 дэх хэсгийг хасахтай холбоотой заалт байгаа юм. Энэ нөгөө хөндөгдөөгүй заалтыг, хөндөгдөөгүй заалтыг хууль зүйн дүгнэлт гаргаж байж хөндөнө гэсэн Дэгийн хуультай учраас яваад байгаа юм шүү. 3.Сонгуулийн сурталчилгааны хугацааг 18 хоног болгосонтой өөрчилсөнтэй холбоотойгоор 38 дугаар зүйлийн 38.12 дугаар хэсэгт заасан хоногт нийцүүлж, 18 хоног болгохтой холбоотой хууль зүйн дүгнэлт гаргах байгаа юм. 4-д нь Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор хуулийг дагаж мөрдөх хугацааг нийцүүлэх, 1 сарын 1 гэдэг юм тавих ийм 4 асуудал дээр хууль зүйн дүгнэлт гаргуулахаар Байнгын хорооноос өнөөдөр ишийдээд, Их Хурлын Тамгын газар хүргүүлчихье.

Тэгээд энэ дүгнэлт нь ирсний дараа эцсийн хэлэлцүүлэг хийхийнхээ өмнө энийг сонсоод явна гэсэн ийм зохицуулалттай юм байгаа юм. Байнгын хорооны гишүүд та бүгдэд дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Тогтохсүрэн даргын танилцуулсан 4 асуудлаар хууль зүйн дүгнэлт гаргуулах нь зүйтэй, холбогдох арга хэмжээ авах нь зүйтэй гэсэн агуулгатай зарчмын саналаар зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Дэмжье горимын санал. 1 дүгээр хэлэлцүүлгийнхээ санал, дүгнэлтэд оруулчих хэрэгтэй юм байна даа Байнгын хорооны ингэж ийм юм бас орсон гээд тийм ээ. Түүн дээрээ анхаараарай. 81,8 хувиар Тогтохсүрэн даргын гаргасан санал дэмжигдлээ. Тэгээд Байнгын хорооноос гарах санал, дүгнэлт дээр үүнийгээ бас дурдаад, тэрнийгээ Тамгын газарт чиглэл болгоод албан бичгээр хүргүүлчихье. Тийм ээ.

17.41 цаг

Баярлалаа. Өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан, дууслаа. Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа. Хуралдаан хаая, хаалаа.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА**

